

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-30

-
- | | |
|--|------|
| 1. Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт заасан “Хэрэв Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ажил эрхлээгүй бол 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж, ... олгоно.” гэснийг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах/ | 6-30 |
|--|------|
-

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын болон Өргөдлийн байнгын хороодын хамтарсан
11 дүгээр сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 57 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 21 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар, Л.Мөнхбаясгалан;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Л.Гантөмөр, Т.Доржханд, Ц.Идэрбат, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Батцэцэг, Л.Мөнхбаатар;

Тасалсан: Х.Баттулга, Х.Ганхуяг, П.Мөнхтулга.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Нэг.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт заасан “Хэрэв Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ажил эрхлээгүй бол 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж, ... олгоно.” гэснийг хүчингүй болгох асуудлаар хуулийн төсөл санаачлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан өргөдөл гаргагч Ц.Батболд оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт Г.Нямсүрэн, С.Уянга, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт Ц.Болормаа, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын иргэн Ц.Батболдоос нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан өргөдлийг Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг танилцуулав.

Нийтийн өргөдөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, С.Бямбацогт, Ц.Даваасүрэн, А.Ариунзаяа, О.Алтангэрэл, С.Зулпхар, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг, өргөдөл гаргагч иргэн Ц.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, Ц.Сандаг-Очир, Б.Пунсалмаа, Ц.Даваасүрэн, А.Ариунзаяа, С.Зулпхар, Г.Уянгахишиг, С.Цэнгүүн, Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн О.Номинчимэг, О.Саранчулуун нар үг хэлэв.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Төрийн байгуулалтын байнгын хороо болон Өргөдлийн байнгын хорооны тогтоолын төслийг Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

О.Номинчимэг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Төрийн байгуулалтын байнгын хороо болон Өргөдлийн байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 15

Бүгд: 41

63.4 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 37 минут үргэлжилж, 57 гишүүнээс 41 гишүүн хүрэлцэн ирж, 71.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 21 минут.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

О.Номинчимэг: Байнгын хороодын эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Өнөөдөр Өргөдлийн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хороодын хамтарсан хуралдаанд гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул 2025 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Нийт 2 Байнгын хорооны 57 гишүүнээс 29 гишүүн, 30 гишүүн ирээд байна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн, Чинбатын Номин гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Саруулсайханы Цэнгүүн гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Баярмагнайн Баярбаатар гишүүн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, Хажикберийн Жангабыл гишүүн, Сархадын Зулпхар гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Батын Батбаатар гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Сонгобайн Замира гишүүн, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Бадарчийн Хэрлэн гишүүн, Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Мөн Далайн Батбаяр гишүүн ирсэн байна.

Ингээд Байнгын хороодын хамтарсан хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хамтарсан өнөөдрийн хуралдаанаар 1 асуудал хэлэлцүүлнэ.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41.49 дэх хэсэгт заасан “хэрэв Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ажил эрхлээгүй бол 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно.” гэснийг хүчингүй болгох асуудлын хуулийн төсөл санаачлах асуудлаар өнөөдөр хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу. Рэгдэл гишүүний микрофоныг өгье.

Д.Рэгдэл: Асуудал ч яах вэ, ерөнхийдөө ойлгомжтой л байна. Тэгэхдээ энэ чинь шууд хуулийн төсөл санаачлах тухай гээд бид нар хэлэлцэх үү. Эсвэл ажлын хэсэг байгуулах тухайгаа хэлэлцэх юм уу. Шууд хууль санаачилна гэвэл энэ чинь арай өөр юм болоод явчихна шүү дээ.

О.Номинчимэг: Энэ асуудал бол 100 мянган иргэн буюу хуулийн төсөл санаачлах энэ санаачилга дээр 100 мянган иргэн нэгдэж гарын үсэг зураад, журмын дагуу хуулийн хугацаатайгаар энэ 2 эрхэлсэн Байнгын хороодоор орж ирж байгаа. Нийтийн өргөдөл буюу D-Petition-ээр орж ирж байгаа хуулийн төсөл санаачилгатай холбоотой асуудал бол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиараа Байнгын хороонууд энэ саналыг хэлэлцэж эхэлснээс хойш 3 сарын дотор ерөнхийдөө санал, дүгнэлт гаргаж шийдвэрлэнэ гэсэн иймэрхүү арга замуудыг заасан байгаа. Тэгэхээр энэ асуудлыг ер нь нийтийн өргөдлөө цөмөөрөө хэлэлцэнэ. Үүнээс цааш мэдээж чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд байгаа хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг гаргах юм уу. Энэ бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхтэй холбоотой асуудал учраас Засгийн газарт мэдээж чиглэл өгөхгүй байх. Мэдээлэл сонсож байгаа биш, энэ хуулийн төсөл санаачлахтай холбоотой байгаа учраас хяналт шалгалт явуулах, хуулийн төсөл боловсруулах, хяналтын сонгол зохион байгуулах гэсэн арга хэмжээнүүд байгаа юм. Тэгээд ер нь бол Байнгын хороодоор хэлэлцээд энэ арга хэмжээнүүдээс боломжит ямар хувилбар байх вэ буюу Байнгын хорооны тогтоол ажлын хэсэг гаргах, хуулийн төсөл санаачлах тогтоолыг гаргая гэсэн ийм санал байгаа. Судалж үзэх ажлын хэсэг ерөнхийдөө гаргана гэсэн байгаа юм.

Тэгэхдээ энэ өргөдлөө эхлээд бид нар хэлэлцэх ёстой байгаад байгаа эрхэлсэн Байнгын хороод. Ингээд үүний дараа судлах ажлын хэсэг ерөнхийдөө байгуулъя гэж байгаа юм. Өөр асуулттай гишүүн байхгүй байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал хэлж дууслаа. Даваасүрэн гишүүн үг хэлэх үү. Даваасүрэн гишүүний микрофон.

Ц.Даваасүрэн: Ер нь энэ асуудал дээр хэдүүлээ ажлын хэсэг байгуулъя гээд ингээд явсан нь зөв байх. Улсын Их Хурлын гишүүн хүн бас төрийн түшээ хүний байр суурьтай байдаг баймаар байна. Сүүлийн үед хараад байхад гудамжны популизм хэтэрхий хийдэг ийм юм болж байна. Одоо бараг цалингүй ажиллая гэх ухааны юм ярьж эхэлж байна шүү дээ. Энэ тийм баян хүний жаргаж цэнгэдэг газар биш. Энэ бол төр улсаа авч явах гэж байгаа хүмүүс цугладаг газар. Тийм баян байгаа бол өргөдлөө өгөөд зайл. Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал ч гэлээ гэсэн төрийн нууцтай холбоотой. Ийм асуудал гарсан юм.

Жикэгийн үед гарсан юм. Төрийн онц нууцтай харьцаж байсан хүмүүс шууд өөр улс орны иргэн болох, гадаад руу гарах, гаднын компанийн зөвлөх болох, төрийн нууцыг худалдах маягийн ийм хэлбэрүүд явдаг явсан учраас зориуд 1 жилийн хугацаагаар нууцыг хадгалах зорилгоор бол Улсын Их Хурлын гишүүдийг цалинжуулж, төрийн өмнө үүрэг хүлээлгэдэг юм. Энийг тайлбарлахгүйгээр зүгээр шууд л популизм хийчхэж байна шүү дээ. Тэгээд энэ хүмүүс гараад хаачих вэ. Гаднын иргэн болчихвол яаж ч чадахгүй. Гаднын компанид зөвлөх болбол яаж ч чадахгүй. Ингэж хаяж болохгүй байхгүй юу. Тийм учраас 1 жилийн хугацаанд төр тэр хүнтэй хариуцлага яриад, цалинжуулаад, нууц хадгалах үүргийг нь хүлээлгэж байгаа юм. Төрийн онц нууцтай 4 жил харьцаж байгаа хүмүүс шүү дээ эд нар чинь. Ингэж бодож хандаач ээ. Нэр хүндээ өсгөхийн төлөө энэ төрийн тогтолцоогоо сулруулдаг байж болохгүй. Энийг зарим нэг нөхдүүд ойлгомоор байна. Арай хэрээс хэтрэх гээд байна шүү. Ер нь төр байна уу, үгүй юү дээрээ тулах гэж байна.

Парламентын тогтолцоо цаашдаа тогтох уу, үгүй юу дээрээ тулах гэж байна шүү дээ. Энийгээ мэрээд хэмлээд байх юм бол энэ парламентын тогтолцоо чинь тэсэхгүй. Өөр засаглал руу явна. Тийм учраас бас төрийн түшээ хүн шиг хандаад, ажлын хэсэг байгуулаад, энийгээ нухацтай сайн ярьцгаа.

Магадгүй тэр гэрээгээ чангатгах хэрэг байж магадгүй. 1 жилийн хугацаанд тэр хүнийг төрийн нууц хадгалахын тулд харин гэрээг нь чангатгаад, ийм ийм үйлдлийг бол хийж болохгүй, гадагшаа гарч гаднын иргэн болж болохгүй гэдэг ч юм уу иймэрхүү юмнуудыг нь бол чангатгах шаардлага байж магадгүй. Ер нь гаднын компанийн зөвлөх хийхийг нь ч хорьж өгөх хэрэгтэй. Энэ хугацаанд бол. Ийм л зүйл шүү дээ. Энэ бол попрох зүйл биш. Тэгээд энэ дээр хэдүүлээ ажлын хэсэг байгуулаад явъя.

О.Номинчимэг: Хэлэлцэх асуудалтай холбогдуулан гишүүд үг хэллээ. Одоо хэлэлцэх асуудалдаа оръё.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5-д “нийтийн өргөдлийг цахим системд 30 хоногийн хугацаатай байршуулах ба уг өргөдлийг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэдийн дэмжсэн санал дараах тоонд хүрсэн тохиолдолд Улсын Их Хурал авч хэлэлцэнэ.” гэж, 39.5.1-д “хуулийн төсөл санаачлах саналыг 100 мянга ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол” гэж заасны дагуу Монгол Улсын иргэн Цогбадрахын Батболдоос Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг буюу “хэрэв гишүүн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ажил эрхлээгүй бол 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно” гэсэн заалтыг хүчингүй болгуулах асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдлийг 2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 45 минутад ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл гомдлын системд 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр байршуулсан байна.

Тус нийтийн өргөдлийг 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт 100.376 иргэн дэмжсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-д “нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хууль хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанд хуралдаан даргалагч Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулж, Төрийн байгуулалтын байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд шилжүүлсэн.

Дээрх өргөдлийн танилцуулгыг Байнгын хороодын гишүүд та бүхэнд хүргүүлсэн байгаа. Мөн холбогдох бас хуулийн лавлагаа, судалгаануудыг бол Өргөдлийн байнгын хорооны гишүүдэд бас тараасан байгаа. Ингээд уг асуудлыг хэлэлцэж эхэлье.

Энэ асуудалтай холбоотойгоор тус нийтийн өргөдлийг гаргасан иргэн Цогбадрахын Батболд энэ хуралдаанд өргөдөл гаргагчийг төлөөлж бас оролцож байна.

Нийтийн өргөдөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Асуулт, үг тусдаа байгаа. Аюушийн Ариунзаяа, Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Нийт 6 гишүүн асуулт асууна. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Өргөдөл гаргагчаас асуух юм байна тийм үү. Энэ хууль чинь анх 1997 онд батлагдахдаа Их Хурлын гишүүн үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн бол тэтгэмж нь 6 сар гэж байсан шүү дээ. Тэгээд 2006 оны нэмэлт, өөрчлөлтөөр 12 сар болгочихсон. 2024 оны 5 сарын 16-ны буюу өмнөх парламент бүрэн эрхээ дуусгаахаасаа 1 сарын өмнө энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад өөрчилчихсөн. Тэгээд би уг нь Тамгын газраас асуух гэж байсан юм. Яг өнгөрсөн хугацаанд 1992 оноос хойш, анхны парламент бүрдсэнээс хойш хэчнээн гишүүн байсан хүн энэ тэтгэмжийг авсан юм бэ гэдэг асуулт асуух гэж байсан юм. Хэчнээн хүн. Тэгэхээр одоо энэ чинь өргөдөл гаргагчаас асуух болчихоод байна шүү дээ. Тэгэхээр энд хэн хариулах уу. Өргөдөл гаргагч хариулах боломжгүй болчихлоо шүү дээ.

1992 оноос хойш, бүр яг 1992-1996 оны парламентаас тэд, 1996-2000 оны парламентад тэд, 2000-2004 оны парламентаас хэд, ингээд хамгийн сүүлд 2020-2024 оны парламентаас хэдэн хүн энэ тэтгэмжийг авсан юм бэ гэдэг би тэр мэдээллийг нь мэдмээр байх юм. Тэгэхээр чинь одоо хариулах нь хэн болчхов Номинчимэг дарга аа.

О.Номинчимэг: Энэ нарийн асуудлыг, энэ асуудалтай холбоотойгоор Өрлөгийн байнгын хорооноос Улсын Их Хурлын тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар луу бас бичиг явуулсан. Үүнтэй холбоотой тэтгэмж авч байгаа хүмүүсийн тоо, өмнөх тоонуудыг өгөөч гээд. Тэгээд Тамгын газар бол энэ дээр ажиллаад, тогтоолууд захирамжуудаа шүүж байна гэсэн мэдээлэл өгсөн. Ерөнхийдөө бол үе үеийн одоогоор энэ гэхдээ эцсийн мэдээлэл биш байгаа шүү. 1990-1992 онд АИХ-ын депутат байсан гишүүдээс эхэлсэн юм байна лээ. Тэгээд 1990-1992 онд Улсын Бага Хурлын гишүүн байсан хүмүүсээс 36, 1992-1996 оны тоо бол гараагүй байна. Байхгүй байна. Нөгөө захирамжаа шүүж байгаа учраас. Ингээд 1996-2000 онд 50, 2000-2004 онд 53, 2004-2008 онд 38, 2008-2012 онд 39, 2012-2016 онд 45, 2016-2020 онд 38, 2020-2024 онд 34 гишүүн тэтгэмж авч байгаа гэсэн ийм мэдээлэл. Гэхдээ энийг бол бас дахиж нягтлах ёстой гэсэн ийм мэдээлэл өгсөн учраас албан ёсоор бол одоогоор тараах боломжгүй байна.

Гэхдээ энийг болбол ажлын хэсэг дээрээ дахиж нягтлаад, энэ мэдээллүүдийг аваад, өшөө сайн ажиллахад болох байх. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бол Засгийн газрын гишүүдтэй холбоотой мэдээллийг бас хүссэн байгаа. Хуулийн дагуу 1993 оны Засгийн газрын гишүүнтэй холбоотой бас зохицуулалт байдаг. Одоогоор энэ хариу бол бас ирээгүй байгаа. Өргөдлийн байнгын хороонд мэдээлэл ирээгүй байгаа гэдгийг бас шижир гишүүнд хэлье. Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Тэгэхээр та Тамгын газар луу албан бичиг явуулаад, тоо хүссэн юм байна. Тийм үү. Тэгээд энэ Тамгын газар дээр уг нь ийм хэдхэн тоо бэлэн байдаггүй юм уу. Энэ чинь одоо гайхаад байх юм. 1 байшинд сууж байж. Энэ чинь бичгээр хүсээд байх тоо биш шүү дээ. Яг бодитоор. Одоо хэдүүлээ 1 байшинд сууж байж хоорондоо бичиг шидэлцээд л хэд хонох юм. Та хэзээ явуулсан юм.

О.Номинчимэг: Энийг бол Өргөдлийн байнгын хороогоор хэлэлцэх хуваарьт Улсын Их Хурлын дэд дарга хуваарилсны дараа 4 дэх өдөр бол албан бичгээр хандсан байгаа. Тэгээд би сая танд хэллээ. Тамгын газрынхан бол урьдчилсан энэ тоог бол гаргаад өгчихсөн байгаа. Гэхдээ бас 1992-1996 оныход бол захирамжуудыг

нэг бүрчлэн бас шүүх хэрэгтэй байдаг юм байна. Архив орж. Тэгэхээр энэ бол яг эцэслэсэн тоо биш, одоогийн байгаа мэдээллээр нэг ийм тоонууд бол гаргаж байна. Бид нар бүр нарийвчилж, мэдээж энэ гишүүдийн Даваасүрэн гишүүний хэлсэн бүрэн эрхийн холбоотой асуудал, тоонуудыг нягталж гаргахгүй бол дараа нь нийгэмд буруу мэдээлэл очих вий дээ гэсэн болгоомжлол байгаа учраас эцэслэсэн биш гэдэг утгаар өгсөн. Зарим тоонуудыг нь бол нягтлах шаардлагатай гэсэн. Тэгээд сая бол ирсэн тоонуудыг нь би танд бас уншиж өглөө. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ амгаланг айлтгая. Миний мэдэхийн 1990-1992 оны Улсын Бага Хурлын гишүүд бүгдээрээ бас орон сууцтай болж байсан. 1992 оноос хойш Их Хурлын гишүүд орон нутгаас сонгогдсон гишүүд нь орон сууцын асуудлаа шийдүүлдэг, сүүлдээ орон сууц өгч чадахгүй болохоороо орон сууцын дэмжлэг үзүүлдэг байсан. Энийг бас нягтлаад харчих нь зөв байх гэж бодож байгаа.

Улсын Их Хурлын гишүүдийг гишүүнээсээ буусных нь дараа цалингийн тэтгэмж өгдөг асуудал энэ 2024 онд 12 сараар өгдөг болчихсон юм уу. 2024 оноос. Урьд нь бол 6 сараар өгдөг байсан юм шиг байна. Тэгээд тийм болохоор энийг бид нар бас анхаарах нь зөв байх.

Тэгээд Их Хурлын гишүүд илүү эрхтэй хүмүүс биш. Илүү ачаа үүрэх ёстой, илүү хариуцлага хүлээх ёстой. Ер нь Их Хурлын гишүүнээр сонгогдох гээд ажиллахдаа ч гэсэн бид нар ерөөсөө л улс орныхоо эрх ашгийн төлөө, ард иргэдийнхээ төлөө өдөр шөнөгүй, нойр хоолгүй, чөмгөө дундартал зүтгэнэ гэж амлаж байгаад, уулзалт хийж байгаад, иргэд, сонгогчдын саналыг авч сонгогддог. Энэ амласан амлалтаа биелүүлэх ёстой, үүргээ биелүүлэх ёстой. Ингэснийхээ төлөө бас илүү эрх эдлэх гээд байх нь бас зохимжгүй байх.

Тийм болохоор бас иргэдийн гаргаж байгаа саналыг би дэмжиж байгаа. Дэмжиж байгаа. Иргэдтэйгээ адилхан эрхтэй байя. Өөрсдөө Их Хурлын гишүүн болох гэж хүчээр тулгаж байж хүчээр гишүүн болгоогүй. Өөрсдөө дурлаад, өөрсдөө чөмгөө дунд дундартал зүтгэнэ гэж гишүүн болчихоод би илүү эрх эдэлмээр байна, илүү хангамж эдэлмээр байна гэдэг бол зохимжгүй. Бидэнд Их Хурлын гишүүдэд тойрогтоо ажиллах, иргэд сонгогчидтой уулзах, хууль тогтоолын төсөл санаачлах, хууль тогтоолын төсөөллийн хэрэгжилтэд нь хяналт тавих ийм тодорхой төсвүүд байдаг. Энэ хүрээндээ л үйл ажиллагаагаа явуулаад, яваад байх нь зохимжтой байх.

Тийм болохоор бас иргэдийн гаргасан саналыг бид анхааралтай авч үзье. Их Хурлын гишүүн байна гэдэг бол эрх ямба биш ээ, үүрэг хариуцлага. Энийгээ бид нар бас онцгой анхаарч ажилламаар байна. Энэ иргэдээсээ илүү эрх эдлээд байгаа, иргэдээсээ бас нуугаад байгаа энэ чинь л хардлага төрүүлж байгаа. Төрд итгэх ард иргэдийн бас итгэлийг алдагдуулж байгаа. Тийм болохоор л энэ дээр хэдүүлээ нэгэнтээ үүрэг, тангараг өргөсөн юм бол тангарагтаа үнэнч байцгаая, үүргээ биелүүлцгээе. Энэ тал дээр бас энэ хууль, тогтоолын төслөө хэрхэн яаж сайжруулах юм. Үеийн үед л яваад л байсан л даа. Цаашдаа бас энэ орон сууцын хангамж дэмжлэг гэж байгаа асуудал байгаа юм уу, байхгүй юм уу. Энэ дээр бас тодорхой нэмэлт хариулт өгөхгүй юу. Тэгээд иймэрхүү илүү хангамжуудаа бас эргэж харъя. Бас алдаа байдаг бол алдаагаа засъя. Энэ дээр Байнгын хорооноос.../минут дуусав/

О.Номинчимэг: Бямбацогт гишүүн бараг л үг хэлчихлээ. Тийм үү. Тамын газраас асуулт асуусан уу. Энэ асуултыг нь Тамгын газар тэгвэл тэмдэглэж аваад,

ажлын хэсэг дээр байна уу, энэ мэдээллийг нь өгнө биз ээ. Яах вэ, Өргөдлийн байнгын хорооны гишүүн бол та биш тийм ээ. Тэгэхээр бид нар бол Өргөдлийн байнгын хороондоо бүх хуулийн лавлагаануудыг бол хүргүүлсэн байгаа юм. Тэгээд анх бол энэ Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль гээд 1997 оны 2 сарын 6-нд ийм хууль батлагдаж байсан юм байна. Энэ хуулиар бол 6 сарын хугацаанд Их Хурлын гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс буурахааргүй тэтгэмж, хэрэв бага цалинтай ажил эрхэлж байсан бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж мөн хугацаанд олгоно гэсэн ийм 9 дүгээр зүйл заалт орж ирж байсан юм байна. Тэгээд ер нь бол 6 сар гэдгээс эхэлж байсан. Энэ хууль дараа нь хүчингүй болоод, Монгол Улсын Их Хурлын тухай хууль 2006 онд батлагдахдаа 12 сар болсон юм байна. Тэгэхээр 2006 он гэдэг чинь 20-иод жилийн өмнөөс энэ хууль нь бол байсан гэсэн ийм хуулийн лавлагаа байгааг бас энд хэлье. Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Би энэ асуудлыг хөндөөд байгаа хүнээс нь асууя даа. Тэгэхээр энэ асуудал маань өөрөө хариуцлагатай холбоотой зүйл байхгүй юу. Яах вэ, иргэн хүний хувьд ч гэсэн ялгаа байхгүй шүү дээ. Ажилгүйдэл гээд л ажилгүй болсныхоо тэтгэмжийг, халамжийг аваад л явж л байгаа. Бүгд хууль тэгш байх ёстой. Гишүүн байсан ч бай, иргэн байсан ч бай тэгш байх ёстой. Тэр агуулгаараа. Тэгэхдээ үүнээс гадна хамгийн гол бий болсон юм бол би түрүүн хэлсэн. Төрийн нууцтай холбоотой. Энэ хүмүүс 4 жил төрийн нууцтай харьцаж ажиллаж байгаа. Давамгай мэдээлэлтэй болж байгаа. Тэгээд ийм хүмүүсийг бол бусад улс оронд гудамжинд хаядаггүй. Германд бол тэтгэмж нь ер нь шууд үргэлжлээд яваад байдаг байх. Ямар ч гэсэн бүрэн эрхийн хугацаатай тэтгэмжийг өгдөг. Тэгээд хаанаасаа ийм юм бодоод олчхов. Одоо энэ хүмүүс хэрвээ гудамжинд гараад гадаад улсын компаниудын зөвлөх болох гэдэг юм уу, гаднын иргэн болох, энэ мэдээллээ ашиглаж амьдрах энэ боломжийг нээж өгөх ямар шаардлага байгаа юм бэ: 1 жилийн хугацаанд эд нарыг бас нууцын хугацаатай нь тодорхой хэмжээгээр ингээд цалинжуулаад гэдэг юм уу, тэтгэмжийг нь өгөөд, ингээд хамгаалж байгаа энэ төрийн бодлогыг нураах ямар хэрэг байна. Энэ чинь өөрөө төрийн өмнө хариуцлага хүлээх ёстой хүмүүс шүү дээ. Төрийн онц нууцтай харьцаж байгаа төрийн өндөр албан тушаалтнууд. Тэгээд энэ хүмүүсийг гудамжинд гарсны дараа яаж энийг хязгаарлах вэ. Одоо ингээд гаднын компаниуд бол ашиглаж эхлэх байх л даа. Дараа нь зөвлөх болгоод ч юм уу. Одоогоор бол зөвлөх болоод гүйгээд байгаа юм байхгүй байгаа шүү дээ. Энэ төрийн нууцыг нь хадгалах асуудлыг яаж зохицуулъя гэж бодож байгаа юм.

О.Номинчимэг: Өргөдөл гаргагчаас асуулаа. 6 номерын микрофон.

Ц.Батболд: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Даваасүрэн гишүүний асуулгад хариулъя. Тэгэхээр өнөөдөр энэ тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж гэдэг асуудлыг Улсын Их Хурлын гишүүн ийм хэмжээнд ойлгож байна гэдэгт бол би бас их харамсалтай байна танд. Тэгэхээр тэтгэмж гэдэг ойлголт, тэр дундаа ажилгүйдлийн тэтгэмж гэдэг ойлголт өөр байдлаар тайлбарлагддаг. Би өөрөө Өргөдлийн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хороонд хуульч хүний хувьд гаргасан нийтийн өргөдлийнхөө шалтгаан, учир холбогдол, хууль зүйн дүгнэлтийг бүрэн хийгээд аваад ирсэн байгаа. Одоо өгнө. Энэ хуралдааны дараа.

Тэгэхээр тэтгэмж гэдэг өөрөө Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу эрх үүссэн даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, ажилгүй болох тохиолдолд түүнд өөрт нь болон нас барсан тохиолдолд гэр бүлийн гишүүдэд нь олгодог мөнгөн халамжийг хэлээд байгаа юм. Тэгэхээр та бүгдийн баталсан энэ Улсын Их Хурлын тухай хуулийн 41

дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн 41.9 дэх заалтад “гишүүн хэрвээ дахин сонгогдоод ажил эрхлээгүй бол” гэж байгаа юм. Тэгэхээр энийг ажилгүйдлийн тэтгэмж гэж ойлгохоос өөр ойлгох хууль зүйн ойлголт байхгүй.

Тэгэхээр 2023 оны 7 дугаар сарын 7-нд та бүгдийн баталсан Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж олгох тухай хууль байгаа. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт жирийн иргэддээ зориулаад та бүхэн хууль батлахдаа та ажилгүйдлийн тэтгэмжийг ажилласан жилээсээ хамаарч, сүүлийн 9 сарын хугацаанд авсан ажлын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогынхоо 50-70 хувь хүртэл авна гэдгийг хуульчлаад өгчихсөн байдаг. Гэтэл жил хүрэхгүйн дараа буюу 2024 оны 5 сарын 16-ны өдөр өөрсдөдөө зориулж баталсан хуульдаа болохоор Улсын Их Хурлын гишүүн дахин сонгогдоогүй бол гэж байгаа юм. Ажил эрхлээгүй бол. Та бүгд бол дахин сонгогдох, сонгогдохгүйгээ мэдээж өнөөдрийн хийж байгаа ажлын чинь үр дүнгээс шалтгаална шүү дээ. Ард иргэд дүнгээ тавина. Би 4 жил намайг сонгоод өгөөч. Би 4 жил л ажиллах юм гэдгээ илэрхийлчхээд, мэдэгдчихээд, тэгээд сонгогдчихоод, дараа нь би ажилгүйдлийн тэтгэмж авъя. Гэхдээ жирийн иргэдээсээ илүүтэйгээр би 12 сарын хугацаанд бүтэн 1 жилийн хугацаанд 100 хувиар авна. Би цалингийн зөрүүтэй ажилд орвол би бүр тэр байтугай зөрүүгээ авна. Хөдөө, орон нутаг руугаа буцвал би бүх замын зардал, ачаа тээшээ улсаар, төсвийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгөөр зөөнө гэсэн ийм хуулийн заалттай байгаа учраас энэ хуулийн заалт өөрөө цаашилбал Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 заалтыг хоёуланг нь зөрчиж байгаа. Өөрөөр хэлбэл хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, энэ эрхэлсэн ажил, албан тушаал гэдгийг би тодотгож байгаа шүү. Шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэсэн энэ заалт байгаа. Хүн бүр эрх зүйн этгээд байна. Дээр нь Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө, хуулийн өмнө шүү тэгш байна гэдэг чинь Үндсэн хуульдаа заачихсан. Бид Үндсэн хуульд захирагдаж, Үндсэн хуулиа дээдэлж, Үндсэн хууль засаглах ёстой гэсэн нийгмийг сонгоод, 30 гаруй жил туулж явцгааж байна. Тэгэхээр таны энэ хэлж байгаа асуудал дээр бол би мэдээж 100 мянган иргэнийхээ цахим гарын үсэг зурсан энэ санаа өргөдлийг дэмжиж, эсэргүүцэх байр сууринаас хэлж байна.

Таны тэр яриад байгаа гишүүн дахиж сонгогдохгүй бол хаачих юм бэ., гудамжинд гарах гээд байна гээд яг л гудамжинд гарч харагдаач. Гадаадын компанид яваад өгдөг гэнэ үү. Энэ чинь өөрөө тусдаа өөр хуулиар зохицуулагдана. Нууцын тухай хууль гэж бий. Та бүгдийн өргөсөн тангараг бий. Улсын Их Хурлын гишүүн би ингэж, ингэж ажиллана..../минут дуусав/

О.Номинчимэг: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, яах вэ. Өнөөдөр ингээд популизм ноёрхчихсон ийм сошиал орчинд бол хүмүүс ингэж л хандаад байгаа юм л даа. Үүний цаана төрийн нууцын асуудал. Төрийн нууц өөрөө хугацаатай. Төрийн нууцыг хадгалахад тодорхой гэрээтэй ажиллах ёстой. Чи бусад орны парламентуудыг судалж үзсэн үү. Бүх гишүүд нь тийм байгаа. Германых бол бараг насаар нь байгаа байх. Яагаад гэвэл энэ хүн төрийн онцгой нууцтай харьцаж байгаа хүн. Давамгай мэдээлэлтэй хүн. Энэ талаас нь төрөө тогтвортой байлгах талаас нь хандаж бодсон уу. Манайхаас төрийн онцгой нууцтай харьцаж байсан хүн гаднын иргэн болсон тохиолдол хүртэл бий. Төрийн онцгой нууцтай харьцаж байсан хүн, Бригадын генерал хүн. Тэгээд энэ бүгдийг яаж зохицуулах юм бэ цаашдаа. Чи зүгээр хууль дээр байхгүй. нийг чинь .../минут дуусав/

О.Номинчимэг: 6 номерын микрофон нэмэлт хариулт.

Ц.Батболд: Би өөрийн ажиллаж, амьдарч, сурч байсан БНСУ-ын жишээг энд хэлж тайлбарлая. Солонгос Улсын Үндэсний ассамблей бол 300 гишүүнтэй ажилладаг. Эдгээрт бол энэ ажилгүйдлийн тэтгэмж гэдэг ойлголт байдаггүй. Ард иргэдийнхээ даатгалын ажилгүйдлийн санд адилхан хамрагдаад, дахин сонгогдоогүй бол жирийн иргэнийхээ адил та бүгдийн баталсан нөгөө Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж олгох тухай хууль гээд байгаа шүү дээ. Тэрнийхээ дагуу та ажилласан жилээ тооцуулаад хэдэн хувиар авах ёстой юм бэ, түрүүгээрээ л аваад явах ёстой.

БНСУ-ын парламент буюу ассамблей 2013 он хүртэл бол ажилгүйдлийн тэтгэмж нэрээр биш, зүгээр тэтгэврийн тэтгэмж гэдэг байдлаар 1 удаа тусламж олгодог байдлаар хууль хэрэглэж байгаад, 2013 оноос хойш буюу 19 дэх ассамблейгаас хойш энэ байдлаа өөрсдөө ард түмнээсээ ичээд цуцалсан байдаг. Одоогоор бол БНСУ-ын ассамблейн гишүүн .../минут дуусав/

О.Номинчимэг: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Цогбадрахын Батболд иргэнд уурлаж бухимдаад яах вэ дээ. 100 мянган хүний гарын үсгийг цуглуулаад, иргэдийн өргөдлийг авч хэлэлцэх нь бол зүйтэй.

Миний хэлэх гээд байгаа болон Даваасүрэн гишүүнтэй санал 1 байгаа юм нь юу вэ гэхээр парламентыг, нэн ялангуяа энэ шинэ 126 гишүүнтэй парламентыг бас муухай харагдуулах, албаар улс төржүүлсэн, сэвсэн ийм асуудлууд л ер нь бол ажиглагдаад байгаа. 126 гишүүн л одоо үүнийг батлаад, өөрсдөө л давуу байдал эдлээд байгаа юм шиг ийм хандлагыг бий болгоод байгаад нь бол жоохон эгдүүцээд байгаа юм.

1990 оноос хойш явж байгаа, 1997 онд 6 сар болгосон, 2006 онд 12 сарын тэтгэмж болгосон энэ асуудал 2024 онд сонгогдсон 126 гишүүнтэй бол уг нь холбоогүй л юм байгаад байгаа юм. Тэгээд яах вэ, өнөөгийн нөхцөл байдалд тэртээ 1990 онд батлагдаж байсан хуулийг өнөө цагтаа нийцүүлэн өөрчлөхийг бол дэмжиж байгаа.

Давуу байдал эдлээд байгаа асуудал бас байхгүй. Ажилгүйдлийн тэтгэмж авахаас үл хамаараад Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1 дээр тухайн байгууллагад хэдэн жил ажилласнаас хамаарч ажил олгогч тэтгэмж өгөх үүрэгтэй. Даанч энэ үүргийг өнөөдөр яг хэрэгжүүлж байгаа юу, үгүй юу, Хөдөлмөрийн тухай хуулиа хүмүүс мэдэж байгаа юу, үгүй юу гэдэгт л санаа зовж байгаа.

Өнөөдөр төрийн албан хаагчдын 9 хувийн цомхотголд өртсөн төрийн албан хаагчдадаа төр энэ тэтгэмжийг нь өгч байгаа юу, үгүй юу гэдэг бол бас асуултын тэмдэг. Зөвхөн Улсын Их Хурлын гишүүд энэ тэтгэмж аваад байдаг асуудал бас огт биш. Та хэд маань уг нь бол бүгдийг нь адил тэгш авч үзнэ гэх юм бол 3 институцийн 3-уулаа яг адилхан тэтгэмжтэй. Ерөнхийлөгчийн хууль дээр бол 1993 оноос хойш насан туршийн цалин бас авдаг. Засгийн газар, Ерөнхий сайд ажил эрхлээгүй бол 6 сарын тэтгэмж авдаг 2000 оны одоо хууль байна. Зөвхөн Улсын Их Хурлын гишүүд парламентыг боорлоод муулаад байдаг нь бол ердөөсөө бас буруу.

Үндсэн хууль ч гэсэн бүгд адил тэгш эрхтэй байх талаар, гадуурхагдахгүй байх талаар уг нь заасан байдаг. Улсын Их Хурлын гишүүний хүүхэд болж төрснөөрөө тухайн хүүхэд хэчнээн мэдлэг чадвартай. өөрийн ур чадвараар, өөрийн мэдлэгээрээ явсан ч гэсэн тэтгэлэгт хамрагдаж чадахгүй ийм нөхцөл байдлыг хүртэл бид нар бий болгосон. Тухайн хүүхдийн эрхийг бид нар ноцтой зөрчсөн. Үгүй ээ, энэ Улсын Их Хурлын гишүүн чинь тийм баян хүмүүс биш шүү дээ. Цөөхөн хэдхэн хүнээр төсөөлж, бүгдийг нь ингэж хоморголон .../минут дуусав/

О.Номинчимэг: Ариунзаяа гишүүн нэмэлт 1 минут.

А.Ариунзаяа: Бүгдийг нь ингэж хэлмэгдүүлж, хоморголон муулж, хүний эрхэд нь бас халдаж боломгүй байна л гэж би хэлмээр байгаа юм. Тэгээд ажлын хэсэг ажиллаад, бас тодорхой энэ хуулийнхаа дагуу гарц шийдлүүдийг олно биз.

Улсын Их Хурлын гишүүний ах, дүү болсноороо төрд ажиллах эрхээ хасуулж, эхлүүлсэн бизнесээ зогсоож, үр хүүхдүүд нь хүртэл тэтгэлэг авах эрхээс хасагдаж явж байгаа нь бол үнэхээрийн үндсэн эрхийг нь зөрчсөн үү гэхээс биш нэг их давуу байдал олгосон асуудал огт биш. Тэр цалингүй ажиллая, ингэе, тэгье гэдэг тэр олигархуудын үгээр биднийг төсөөлж болохгүй шүү дээ. Бас харамсаж байна. Улсын Их Хурлын гишүүд болон төрийн бодлого, шийдвэр гаргаж байгаа хүмүүс ч гэсэн өөрсдөө хариуцлагатай баймаар байна. Ижил тэгш хандмаар байна.

Өнөө цагтаа нийцүүлээд яах вэ, та хэд маань хуулийн гаргалгаагаа гаргаж болно. Энийг бол нэг их эсэргүүцээд байгаа асуудал алга.

О.Номинчимэг: Ариунзаяа гишүүн үг хэллээ. Оюунсайханы Алтангэрэл гишүүн.

О.Алтангэрэл: Ингээд 100 мянган хүний гарын үсэг цуглуулаад, бүрдүүлээд тэгээд тодорхой асуудлыг хөндөж тавиад, олон нийтэд хүргэнэ гэдэг бас амаргүй л дээ. Тэгээд энэ давааг ямар ч байсан даваад, энэ асуудлыг хэлэлцүүлж байгаагийн хувьд Батболдод баяр хүргэх ёстой байх.

Надад бол 2 үндсэн асуулт байна. 1 дүгээрт, та энэ өргөдлийг санаачлахдаа сая бас хууль зүйн үндэслэлүүдийг хэлж байна. Ер нь Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол та түрүүн дурдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн зүйл заалтыг дурдаж байна. Энэ хуулийн дагуу бусадтайгаа адилхан эрх эдлээд, энэ хуулийн дагуу зохицуулагдаад явах ёстой гэж үзэж байна уу. Эсвэл ерөөсөө ямар ч тэтгэмж төрөөс энэ хуулийн дагуу ер нь ямар ч зүйл авахгүй байх ёстой гэж үзэж байна уу гэдэг 1 дүгээр асуулт. Өөрөөр хэлбэл бусад хүмүүсээс бусад ажил хөдөлмөр эрх эрхэлж байгаа хүмүүсээс илүү дордуулсан гэх үү, илүү муу статуст ажиллах ёстой хүн үү таны бодлоор гэж 1 дүгээр асуулт.

2 дахь асуулт бид бол одоо бараг 20-иод жилийн өмнө батлагдсан хуулийг ажлын хэсэг гаргаад, өөрчлөөд ингээд явчхаж болох байх. Тэр нь ч зөв байх. Би бол бусад иргэдтэй адилхан байх энэ зүг рүү энэ саналыг бол дэмжиж байгаа. Илүү эрх ямба эдлэх гээд хүсээд юм уу, зүтгээд байх Улсын Их Хурлын гишүүд бол ерөөсөө байх ёсгүй. Тэгэхдээ өнөөдөр жагсаалт буюу пропорциональ тогтолцоогоор парламентын гишүүд сонгогддог болсон. Тэгээд бид одоо хараагаа өөрчлөх ёстой юм шиг байгаа юм. Заавал их мөнгөтэй, бизнес хийдэг тийм хүмүүсийг бид нар сонгох ёстой. Мөнгөтэй хүнийг сонгох ёстой гэдэг бодлоо өөрчилнө. Магадгүй эндээс хүн хаанаас ч сонгогдож болно. Малчин хүн сонгогдож болно. Монголын

парламентад малчин хүн сууж байсан жишээ байгаа. Эмч хүн, багш хүн жирийн ажлаа хийдэг хүмүүс сонгогдож болно. Энэ хүмүүст хуулийн дагуу таны саяын хэлдэг хөдөөгөөс нүүж ирвэл унааны зардал ч гэдэг юм уу, энэ зүйлүүдийг яг тодорхой хүмүүст өөрсдөө хүсэлт гаргаад үнэхээр өөрийнх нь ашиг орлого, өөрийнх нь хувийн байдал хүрэхгүй бол ийм дэмжлэг үзүүлж ер нь болох уу цаашдаа таны бодлоор. Өөрөөр хэлбэл Монголын парламентад зөвхөн мөнгөтэй ийм хүмүүс сонгогдох ёстой юу. Энэ үзэл бодлоороо, эзэмшсэн мэргэжил боловсролоороо, өөрийнхөө үйлсээр сонгогдох хүмүүс энэ зам бол нээлттэй байх ёстой юу таны бодлоор гэсэн эдгээр асуултуудад би хариулт авъя.

О.Номинчимэг: 6 номерын микрофонд өргөдөл гаргагч Батболд.

Ц.Батболд: Монгол Улсын Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь төрийн сүлдэнд тангараг өргөснөөр эхэлж, дараагийн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөснөөр эрх нь дуусгавар болж байгаа. Тэгэхээр та бүгд энэ төрийн эрх мэдлийг барьдаг энэ албан тушаалтны хувьд аль ангилалд явдаг гэдгээ ойлгох хэрэгтэй. Мэдээж улс төрийн албан тушаалтан. Хугацаатай байгаа. Тийм учраас эрх дуусчхаж байна шүү дээ. Тэр өдрөөсөө эхлээд та бүгдэд жирийн иргэн гэдэг статус үйлчлэх учраас тэр 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиараа ажилласан жилээ тооцуулаад, 50-70 хувьдаа ногдсон тэтгэмжээ аваад явчхаач ээ. Өөрсдийгөө битгий онцлооч ээ гэж байгаа юм.

Урьд өмнөх энэ хуулиуд дээр бол мэдээж тэтгэмж, халамж тэтгэмж гэж бас 1997 оны хууль дээр байхгүй байгаа. 6 сар гэж байсан. Саяын тэр ачаа тээш буцахад зардал гаргана гэдэг зүйлүүд байгаа. 2006 оны хууль дээр ажил эрхлэх хүртэл нь 12 сар хүртэл гэж байсан хугацаа нь 12 сар хүртэл. 1 сар ч байж болох нь байна шүү дээ. 2 сар ч байж болох нь. Гэтэл 2024 оныхоо хуульд оруулж ирэхдээ энд хуулийн хулгай хийчихсэн. Бүтэн 12 сараар заавал авна. Үндсэн цалингаа 12 сар, 1 жилээр бүтнээр нь авна. Ийм онцлогууд байгаа шүү өмнөөсөө.

Одоо өөрсдийнхөө энэ тэтгэмжийн байдал, ажилгүйдлийн тэтгэмж гэж та нарт байх ёсгүй гэж миний өргөдөл гаргагчийн зүгээс үзээд байгаа шүү дээ. Гэтэл энэ тэтгэмж гэдэг байдлаар орж энийг ард түмэн мэддэггүй. Улсын Их Хурлын тухай хуулийг тэр болгон хараад, хянаад, үзээд байх боломжгүй. Гэтэл бага багаар орж ирсэн байна. Хамгийн сүүлд энэ хууль санаачлагч оруулж ирэхдээ 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг гээд ингээд бүтэн оруулаад ирсэн нь өөрсдөдөө цөөнхийн эрх ашгийг хамгаалсан, хууль баталдаг гэдэг давуу байдал бий болгож байгаа байхгүй юу.

Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад 1 удаагийн буцалтгүй тусламж олгох журам байдаг. Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол гээд байгаа юм. Энд зориудаар төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчдыг гэж оруулж өгсөн. Өөрөөр хэлбэл энэ чинь өөрөө ажил олгогч, ажилтан 2-ын хөдөлмөрийн харилцаанаас үүссэн халамжийн асуудал байхгүй юу. Тэр хүн хэдийд ажлаас халагдах, хэдийд ажлын чадвараа түр алдах, яах ийхээ мэдэхгүй байж байгаад хөдөлмөрийн харилцаа дуусгавар болчхож байгаа юм. Энэ тохиолдолд дараагийн ажилдаа эдгэртлээ, ортлоо асуудлаа зохицуулж бай энэ мөнгөөр гээд тэтгэмж өгөөд байгаа биз дээ. Гэтэл хугацаатай 4 жил сонгогдоно гэдгээ мэдэж байгаа. Та бүгдийн хувьд. 4 жилийн дараа би ажилгүй болно. Дахин сонгогдохгүй

бол. Дахиад 1 жил үнэгүй Улсын Их Хурлын гишүүний цалинг аваад амьдарчихъя гэсэн ойлголт байж болохгүй. Та бүгдийн дархан эрх ямба бусад энэ үйлчилгээтэй холбоотой асуудлаар хөндөөгүй шүү. Тэр дахин сонгогдохгүй бол дараа нь нууцаа яаж хадгалах, яаж ажил хөдөлмөрөө хэрэглэх гэдэг Даваасүрэн гишүүний яриад байгаа асуудал бол тусдаа өөр эрх зүйн зохицуулалтаар зохицуулагдах ёстой асуудал. Баярлалаа.

О.Номинчимэг: Алтангэрэл гишүүн тодруулъя.

О.Алтангэрэл: Энэ 2006 оны хууль дээр энэ саяын ярьж байсан зүйлүүд байсан байна л даа. 12 сар хүртэлх энэ тэр гэдэг чинь биш байна шүү. Та бас нягтлаад хараарай. Энгийг бол өөрчлөх нь бол зөв. Тэгэхдээ ер нь өөрчлөх өөрчлөхдөө бид нар цаашаагаа энэ асуудлыг ер нь цогцоор нь харах ёстой юм шиг байгаа юм. Бид нарын бодох ёстой зүйл тэр парламентын засаглалын тухай манай Даваасүрэн гишүүний хэлээд байгаа ч зөв. Бид нар ерөөсөө буруу, муу муухай болгон л эндээс эхтэй, эндээс гардаг гэсэн энэ ойлголт руу хөтлөхгүй л байх ёстой. Засаж сайжруулах юмаа засаж сайжруулах ёстой. Тэр тэтгэмжийг багасгаад, зохих хэмжээнд нь хүргээд бид нар засаж янзлах ёстой. Тэгэхдээ үндсэн зарчмаа бодож байх ёстой. Монгол Улсын парламентад заавал мөнгөтэй хүн сонгогддог байх албагүй. Энэ нөхцөл байдлыг л бид нар бас сайн бодож байх ёстой шүү. Үг хэллээ.

О.Номинчимэг: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга,эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Манай өргөдлийн цахим системд 100 мянган иргэдийн өргөдөл хүлээж авч, хууль санаачлах эрхээ нээсэн энэ үзэгдэл бол өөрөө бас тийм шинэ зүйл. Шинэ мөртөө бидний хувьд бол иргэдийн оролцоог улс төрийн үйл явцад засаглалын үйл явцад хангах бас сайн ийм жишиг болж байгаа гэдгийг зориуд тэмдэглэх ёстой.

Энэ ч үүднээс иргэн Цогбадрахын Батболд бас тодорхой асуудлаар санаачилга гаргаж, 100 мянган иргэдийн гарын үсгийг зуруулж, энэ асуудлаар өнөөдөр хэлэлцүүлж байгаа нь бол ардчилсан засаглалын, парламентын засаглалын өөрийнх нь бас давуу тал шүү гэдгийг бас тэмдэглэх ёстой.

Иргэд бол дан ганц сонгуулийн үеэр засаглалын үйл явцад, улс төрийн үйл явцад оролцох биш бусад үед ч гэсэн бас цахим засаглалаар дамжуулаад үйл явцад оролцож байгаа нь бол сайн зүйл шүү гэдгийг бол бид бүгдээрээ хүлээн зөвшөөрч байна.

Тэгэхээр яах вэ, одоо энэ гаргаж байгаа зүйлийнх нь тухайд ярих юм бол саналын тухайд ярих юм бол бид шууд нийгмийн даатгалын сангаас олгодог тэтгэмжийн тухай хуулиар зохицуулагдсан асуудлыг дахиад Улсын Их Хурлын тухай хуулиар та бүхэн давхар зохицуулчихсан байна гэдэг ийм л их энгийн зүйл. Энгийг бол энгийнээр ойлгох юм бол тийм ээ гээд бас бид шууд хүлээгээд авчихдаг. Нийгмийн хамгаалал нь угаасаа тэр хуулиараа зохицуулагдаж байгаа учраас үүгээр зохицуулаад явах бүрэн боломжтой гээд хүлээгээд авчхаж болно. 1 дүгээр асуудал.

Гэхдээ нэгэнтээ энэ чинь парламентын жишээ нь өөрийнх нь үйл ажиллагаа учраас бид аливаа асуудлыг нарийн судалж, дүн шинжилгээ хийж, бас талуудын санал бодлыг бүрэн сонсож, эндээс шийдвэр гаргах чиглэл рүү явах ёстой. Үүнтэй

холбоотой бас өргөдөл гаргагчаас асуулт байна. Та бол их нарийн судалсан байна. Маш сайн. Цаашдаа ч гэсэн энэ асуудлаар илүү нарийн судлах байх гэж бодож байна.

Сая Даваасүрэн гишүүн хэлж байна л даа. Энэ бол дан ганц ажилгүйдлийн тэтгэмжээс гадна бас зарим нэг харилцааг зохицуулсан, зарим нэг зүйлийг бид бас бодсон юм гэж. Тэгэхээр та бол энийг судлах явцдаа энэ хууль хэлэлцэх үеийн архивын материалуудыг үзсэн үү. Тэр саяын хэлээд байсан тодорхой шалтгаанууд байсан уу. Энийг та 1 дүгээрт хариулаач гэж байгаа юм.

2 дахь зүйл бол та бол Солонгосын жишээг хэлж байна. Гэхдээ бидэн дээр бол тайлан байна. Янз янзын улсад янз янзаар зохицуулагдсан байна. Тийм ч байж болно. Ижил ч байж болно, ялгаатай ч байж болно, төсөөтэй ч байж бас болно. Тэгэхээр таны хувьд бусад улсуудын жишгийг судалсан уу. Судлахдаа яагаад тэр улсууд хэрвээ саяынх шиг ажилгүйдлийн тэтгэмжийг гэдэг юм уу, эсвэл жишээ нь парламентын гишүүнийх нь бүрэн эрх дуусгавар болсны дараа тодорхой тэтгэмж олгодог бол тэрийг яагаад олгодог юм бол гэсэн тэр шалтгаан нөхцөлийг та судалж үзсэн үү гэсэн ийм тодорхой асуулт байна.

Дараа нь би санал дээр бас саналаа хэлнэ. Баярлалаа.

О.Номинчимэг: 2 асуулт асуулаа. 6 номер. Өргөдөл гаргагч Батболд.

Ц.Батболд: Улсын Их Хурлын гишүүн дахин сонгогдоогүй бол дараа нь ажиллаж байсан үеийнхээ ажлын нууц, хийж байсан ажлаа хэрхэн хадгалж нууцлах нь бол тухайн хүний ёс зүй, ёс суртахуунтай холбогдож илэрхийлэгдэх асуудал. Энийг хэчнээн ажилгүйдлийн тэтгэмжтэй холбож тайлбарлалаа ч ажилгүйдлийн тэтгэмжээ аваад, одоо өөр компанид тэр хүн үнэхээр ёс суртахуунгүй, ёс зүйгүй хүн бол ажиллаад л явна. Ялгаа байхгүй. Тэгэхээр энэ асуудал дээр бол мэдээж Өргөдлийн болон Төрийн байгуулалтын байнгын хороо дэгийн тухай хуулийнхаа 95 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар гишүүн өөрөө хуулийн төсөл санаачлаад, Улсын Их Хурлын тухай хуулийнхаа 36 дугаар зүйлд заасан хүрээ хязгаарынхаа хараанд хуулиа санаачлаад хэлэлцүүлээд явах боломжтой гэж ойлгож байна.

Автолитар, тоталитар дэглэмтэй улсуудад бол мэдээж энэ ойлголт бол байгаа. Тийшээ судлаад ч хэрэггүй. Ардчилсан тогтолцоот улсуудын хувьд бол иргэдээс сонгогдсон гэдэг утгаараа иргэдээсээ илүү тэтгэмж, давуу байдалтай байх гэдгийг тэд бол энд бол хүлээн зөвшөөрөхгүй. Өөрсдөө тэр хүмүүсийн ёс зүйд нь, ёс суртахуунд нь байдаг учраас би бол энэ Солонгосын жишээг аваад байгаа юм. Би бол Солонгос улсын ассамблейн гишүүд ямар тэтгэвэр, тэтгэмж авдаг юм бэ гэдгийг бол зөвхөн энэ Солонгосын зүгээр сайтаас ухаж олж харсан. Өөр бусад улс орны жишээ ямар байдаг талаар бол Байнгын хороо энэ 3 сарын дотор асуудлыг хэлэлцэх ч юм уу, хуулийн төсөл санаачлах уу гэдэг асуудлаа хэлэлцэж эхлэхдээ судалж, танилцацгаах байх гэж бодож байгаа. Миний хувьд бол нийтийн өргөдөл гаргагч.

О.Номинчимэг: Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Юуны өмнө энэ иргэн Цогбадрахын Батболдоос ирүүлсэн өргөдөлд 100 мянган хүн гарын үсэг дэмжиж, нэгдсэн энэ асуудалд бол яг Зулпхар гишүүнтэй адилхан санал нэгтэй байна. Иргэдийн оролцоо ийм сайн байгаад маш

их баярлалаа. Энэ бол ардчилсан парламентын засаглал дээр бас олж байгаа нэг ололт гэж би харж байна.

Би танаас өргөдөл гаргаж байгаа иргэнээс нэг асуулт асууя. Тэтгэмж гэдэг үг өөрөө нийгмийн ер нь үгийн концепц нь өөрөө нийгмийн эмзэг ч юм уу тэр гишүүд, хүмүүст зориулсан ийм утга агуулга тайлбартай. Социологид ч гэсэн ингээд яваад байдаг. Тэгэхээр энэ үг нь өөрөө Улсын Их Хурлын гишүүнд гэхээр энэ 2-ын хооронд ёс суртахууны ч юм уу, үгийн агуулгын хувьд нийцүүлэхгүй байгаа нь анхны сэтгэлээрээ нэг зүй бус юм шиг ийм сэтгэгдэл төрүүлдэг юм шиг байгаа юм.

Та тэтгэмж гэдгээс илүү ер нь энэ шилжилтийн хөтөлбөр гэдэг агуулгаар нь судалж үзсэн үү. Бусад орнуудад харж байгаа жишгийг харахаар парламентын гишүүн байж байгаад өөр ажилд шилжихэд нь дэмжсэн агуулга маягаар их дэмжлэгүүд байдаг юм байна лээ л дээ. Бусад ялангуяа парламентын засаглалтай орнуудад. Тэгэхээр тэр жишээг судлав уу. 1 дүгээрт.

2-т гэвэл ер нь тэр Солонгост болон бусад таны жишээ болгож байгаа орнуудад чинь энэ тэтгэмжийн зардал эх үүсвэр нь хаанаас зохицуулагддаг, Монголоос хаанаас зохицуулагдаж байгаа хоорондын ялгааг ер нь та харж судалсан уу гэдэг ийм тодруулга бас баймаар байна.

Дээрээс нь ер нь бол манай Улсын Их Хурлын гишүүний ч тэр, эмч нар ч гэсэн дэлхийн бүх л оронтой адилхан, бусад орнуудаас үргэлж л доогуур байдаг. Дэлхийн бусад орнуудад байдаг багш нарын цалин, эмч нарын цалин харьцуулшгүй доогуур байгаатай адилхан Их Хурлын гишүүдийнх ч гэсэн адилхан ийм байгаа. Энэ чинь манай улсын байгаа байдал. Тэгэхээр харьцуулж байгаа орнуудынхаа парламентын гишүүдийн хангамжууд манайд ер нь байгаатай ямар харьцуулалт, нийгмийн хамгаалал нь ямар байдаг юм гэдгийг та харьцуулж ер нь гаргаж ирсэн үү гэсэн ийм 3 асуулт байна.

Яагаад гэхээр бид нар өнөөдөр багш, эмч нарынхаа цалингийн асуудлыг ярьж байгаа. Нийгмийн хамгааллын асуудлыг ярьж байгаа. Ярихдаа бид нар бас л бусад орон ийм байдаг. Энэ хүмүүс чинь ийм олон жил сураад, хөдөлмөрлөөд ажиллаж байхад эргүүлээд энд нь дүйцсэн орлого, цалин нэмэх ёстой шүү дээ гэдгийг гишүүд өнөөдөр яриад байж байгаа. Харьцуулаад. Тэгээд яг энэ шиг зарчим энэ парламентын гишүүдэд ер нь байх уу. Ийм 3 зүйл дээр та өөрийн бодол болон дата мэдээлэл байвал хуваалцаач ээ. Тэгээд би дараа нь тодруулъя.

О.Номинчимэг: 6 номерын микрофон. Өргөдөл гаргагч.

Ц.Батболд: БНСУ-ын аливаа нийгмийн даатгалын тогтолцоо бол манайхаас шал өөр. Ассамблейн гишүүд бол цалингаасаа биш хэн ямар даатгалд тэр байтугай үхсэнийхээ дараа оршуулгынхаа даатгалд хүртэл өөрийн цалингаасаа тодорхой хувийг сайн дураараа даатгаж явдаг. Солонгос улсын ассамблейн гишүүд бол ажилгүйдлийн даатгал гээд жирийн иргэд даатгагддаг даатгалын сандаа өөрөө ажилгүй болбол хэдэн төгрөг тэтгэмж авах юм гэдгээрээ төлөвлөж, тооцоогоо хийж, даатгалаа төлцгөөдөг юм билээ.

Тэгэхээр миний энэ өргөдөл гаргах анх санаа бол ерөөсөө бид Үндсэн хуульд захирагддаг, ардчилсан тогтолцоот нийгэмд амьдарч байгаа иргэд. Энэ дээр үлгэр жишээ болж, түүчээлэх ёстой нь эрхэм гишүүд та бүгд байгаа. Тэгэхлээр Үндсэн хуульд нийцэж гарч байгаа органик хууль Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж

олгох тухай хууль болон Улсын Их Хурлын тухай хууль 2 чинь яг адилхан хүчин чадалтай 2 хууль байхгүй юу. Нийгмийн харилцааг зохицуулж байгаа адилхан. Зохицуулах шинж чанарынхаа хувьд өөр боловч үйлчлэх цар хүрээний хувьд Монгол Улсын нийт иргэн дагаж мөрдөх ёстой ийм органик хуулиуд. Гэтэл энэ 2 хуулийг харьцуулаад үзэхээр жирийн иргэндээ бага байдлаар ажилгүйдлийн тэтгэмж гэж тодорхойлж, хуульчилж өгчхөөд, 10 сарын дараа өөрсдөдөө гаргасан хууль дээрээ болохоор бүтэн авна гээд байгаа нь өөрөө нөгөө Үндсэн хуульд захирах ёстой гэсэн зарчим, хүнийг эрхэлсэн ажил албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно гэсэн энэ зарчимтай харшилж байгаа.

Цаашлаад энэ чинь Үндсэн хуулийн маргаан ч байж болохоор бүр цаашилбал өөрсдийн эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглаж өөрсдөдөө давуу эрх бий болгож байгаа ийм асуудал яригдана. Баярлалаа.

О.Номинчимэг: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Тийм би нөгөө тодруулах гээд асуугаад байгаа нь саяын 2, 3 асуултдаа л асуумаар байна л даа. Бусад орнуудын ялгаа. Тэгэхээр ялгаатай тогтолцоотой орны жишгийг хооронд нь ингээд адилхан байх ёстой гэж ярих нь өөрөө хэр юм бол доо. Би энэ тэтгэмж авах гээд байгаадаа биш байхгүй юу. Таны гаргаж байгаа санал дээр өөр ямар алтернатив шийдэл байж болох вэ гэдэг өнцгөөс харсан уу л гэж асуугаад байгаа юм. Шилжилтийн хөтөлбөрийг судалсан уу. Дэлхийн хэдэн орон парламентын гишүүдэд шилжилтийн хөтөлбөртэй байгааг судлаа юу гэж би асууж.

Нөгөө талд болохоор жирийн иргэдийн ажилгүйдлийн тэтгэмж бага байгаа. Тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнх бүр хэцүү байдаг. Бүр тэтгэмж авч чадахгүй байгаа. Тэр тогтолцооны тухай бид нар ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр гол бид нарын өнөөдрийн хэлэлцүүлгийн зорилго нь жирийн иргэдийн ажилгүйдлийн тэтгэмж дээр анхаарч, энийг шийдэх нь илүү бидний үүрэг, зорилго баймаар юм болов уу. Эсвэл зүгээр үүгээр төлөөлж, парламентын гишүүдийн тэтгэмжийг бууруулна. Тэтгэмж гэдэг юм уу, юу гэдэг юм. Тэрийг бууруулах нь 1 дүгээр зорилго юм уу, аль нь юм бэ. Тэгээд бусад орны жишээгээ харж .../минут дуусав/

О.Номинчимэг: 6 номерын микрофон нэмж хариулт өгье.

Ц.Батболд: Мэдээж ажлын хэсэг байгуулагдаад, хууль санаачлах гишүүн энэ тэр бас тодорхой болоод ирвэл энэ тал дээр хамтарч судалгааны ажил дээр бол оролцох боломжтой. Миний хувьд болохоор сая хэллээ. Адил хүчин чадалтай 2 хуулийн заалт зөрчилдөөд байгаа, Үндсэн хууль зөрчилдөөд байгаа гэж ойлгож байна. Энэ тэтгэмжийн шилжилт. Тэгэхээр энэ тэтгэмж гэдэг зүйлээ өөрсдөдөө ямарваа нэгэн байдлаар дахин сонгогдохгүй бол юу гэдэг юм тийм ээ, бүрэн эрхийн баталгаа гэдэг чинь бол 4 жилдээ харьяалагдана. Гэтэл бүрэн эрхийн хугацаа дууссаны дараах баталгаа гэж авах гээд байгаа бол өөр байдлаар та бүхэн оруулж өгөх ёстой. Энд ажилгүйдлийн тэтгэмжтэй хольж ингэж оруулж ирэхээр таны саяын хэлснээр нийгэмд ойлгох ойлголт, нөгөө хуулийн процедур, хууль Үндсэн хуульдаа нийцэж байна уу. Энэ хууль юу болоод байгаа юм бэ. Энэ Улсын Их Хурлын гишүүн чинь өөртөө давуу байдал бий болгоод байна шүү дээ гэдэг энэ хардалт .../минут дуусав/

О.Номинчимэг: Гишүүд асуулт асууж дууслаа. Яах вэ, энд бас хуралдаан даргалж байгаагийн хувьд энэ хуулийн лавлагаануудыг манай гишүүд бас харчхаарай. Тэгэхээр 1 юм бас тодруулж хэлэхэд, энэ 126 гишүүнтэй парламент бүрдсэнээсээ хойш Улсын Их Хурлын тухай хууль, дан ялангуяа өнөөдөр хэлэлцэж байгаа энэ өргөдөлтэй холбоотой ямар ч зүйл, заалттай холбоотой хууль санаачилж баталсан зүйл байхгүй. Тэгэхээр 1997 оноос хойш энэ бол ийм зохицуулалттай байж ирсэн байна. Өргөдөл гаргагчийн зүгээс энэ бол өөрөө ингээд эрх тэгш байх, давуу эрх олгож байна гэдэг асуудал Үндсэн хуулийн зөрчилтэй байж магадгүй гээд л асуудал тавьж байгаа бол энэ тэгвэл 1997 оноос хойш л явж ирсэн процесс болох гээд байгаа юм.

Тэгэхээр бид хэд бас энэ яг ямар агуулгаар орж ирж байсан юм. Юу зорьж байгаа юм гэдэг зүйлийг нь ёстой хурлын протоколоос нь аваад үзсэн нь дээр байх. 2016 он, 2020 он, 2024 оны 5 сард буюу энэ парламент бүрэн эрхийн парламент бүрдсэнээс өмнөх хуулиудад бол энэ зүйл заалт орсон байгаа. Тэгээд өргөдөл гаргагчийн хувьд бол мэдээж энэ асуудлыг бусад иргэдтэйгээ адилхан байх зарчмыг ярьж байна. Миний хувьд бол бас энийг дэмжиж байгаа. Ингээд энийг бол цааш нь мэдээж өнөө үеийн цаг нөхцөл байдалтай бид 126-тай парламентаар иргэдийн төлөөлөл дуу хоолой болж, энэ төрийн бодлогод оролцох энэ л Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу сууж байгаа хүмүүс. Тэгэхээр энийг бол мэдээж иргэдтэйгээ адилхан энэ асуудлыг цааш нь авч хэлэлцээд явах нь бол зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа юм.

Гэхдээ энэ дээр тодруулж хэлэхэд өөрсдөдөө давуу байдлаар гэдэг энэ байдлыг бол бид нар бас ярихгүй. Танд бас түрүүн хэлсэн. Улсын Бага Хурал 1990-1992 онд ч гэсэн энэ асуудал бас тавигдаад, хуульд орж албажсан нь бол 1997 он байгаа юм байна шүү гэдгийг тодруулж хэлье гэж бодож байна.

Одоо энэ асуудалтай холбоотойгоор үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Цэнгүүн, Саранчулуун гишүүнээр тасаллаа. Өлзийхүүгийн Шижир гишүүн үг хэлье.

Ө.Шижир: Үндсэн хуулийн 14.1 дээр сая өргөдөл гаргагч дурдаж байна. Хүнийг нийгмийн байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлан гадуурхаж болохгүй гээд ингээд заачихсан. Энэ бол төр өөрөө ялгаварлан гардуулахыг бий болгож болохгүй л дээ. Хэрвээ ялгаварлан гадуурхах, ялгаатай асуудалд хандаад ирэх юм бол бухимдал үүсдэг, үл ойлголцол үүсдэг. Үүнээс гарах үр дүнгүүд бол маш өндөр байдаг. Тэгээд энд орж ирж байгаа, орж ирсэн Улсын Их Хурлын гишүүд би гишүүн болбол тэдэн төгрөгийн цалин авна гэж орж ирсэн гишүүн бол 1 ч байхгүй байх.

Нөгөө талаасаа нийгмийн даатгалын сангаас олгодог ажилгүйдлийн тэтгэмж чинь 24 сар Улсын Их Хурлын тамгын газраас бидний нийгмийн даатгалыг төлж байгаа шүү дээ. Цалин өгч байгаа юм чинь. Тэгээд нийгмийн даатгалаараа, хуулиараа ингээд хамгаалагдчихсан юм байхгүй юу. Хуулиараа хамгаалагдчихсан. Одоо жишээ нь Даваасүрэн гишүүн бол 17 дахь жилдээ нийгмийн даатгал төлүүлж байгаа Улсын Их Хурлын Тамгын газраас. Тэгээд энэ чинь хуулиараа ингээд хамгаалчихсан юмнуудыг нь бид нар дахиад ийм ялгавартай байдлыг бас 1 дүгээрт бий болгож болохгүй. Тийм учраас би энэ өргөдөл гаргагчтай 1 дүгээрт санал нэг байна.

Тэгээд зүгээр нэг сонин л жишээ хэлэх юм даа. Сая нөгөө нэлээн бужигнаад Засгийг огцруулах, Улсын Их Хурлын даргыг огцруулах гэдэг асуудал Их Хурал дээр явахад маш олон гишүүд жирийн иргэн гэж ярьж байна лээ. Үгүй ээ, бид чинь

касстын системтэй улс болчихоогүй биз дээ. Бид хугацаатай л ажил хийж байгаа хүмүүс шүү дээ. Дахин сонгогдвол 8 жил, дахин сонгогдвол 12 жил. Одоо энэ сэтгүүлч, зурагчин гэдэгтэй л адилхан Улсын Их Хурлын гишүүн л гэдэг тодотголтой л ажил хийж байгаа шүү дээ. Тэгээд зүгээр яг энэ хууль нэгэнт хөндөгдсөнөөр би бол 1 юм оруулж өгмөөр санагдаад байна. Одоо ажлын хэсэгт хандаж хэлэхэд. Ер нь Улсын Их Хурлын гишүүн ажлаа өгөөд гадаадын иргэн болох, гадаадын байгууллагуудад ажиллах ийм зүйлүүдийг нь хааж өгөх хэрэгтэй. Бүр хуулиараа. Тэгэхгүй бол Хил хамгаалах газрын дарга байсан, Улсын Их Хурлын гишүүн байсан хүн гаднын иргэн болоод тэнд очиж суурьшсан ийм тохиолдол байгаа шүү дээ. Энэ асуудлуудыг нь бид нар хуулиар хааж өгөх хэрэгтэй. Энэ чинь нэг биш тохиолдол байгаа шүү дээ. Би энийг л хэлэх гэсэн юм.

Ер нь бол тэгээд энэ чинь нийгмийн даатгалын сангийнхан хуулиараа энэ чинь асуудлыг нь шийдээд, нийгмийн хамгаалалтыг нь шийдээд өгчихсөн байхад давхар эрх эдэлж яах гээд байгаа юм. Хөдөлмөрийн хуулиараа л адилхан зохицуулаад л явъя л даа. Тийм учраас би энэ өргөдөл гаргагчтай санал нэг байгаа.

О.Номинчимэг: Цэндийн Сандаг-Очир дарга.

Ц.Сандаг-Очир: Би өргөдөл гаргагчид 1 зүйлийг хэлье. Тэр таны яриа дээр 12 сарын тэтгэмжийг 1 удаа бөөнд нь авдаг юм шиг юм яриад байгаа юм. Тийм биш юм байна лээ шүү. Тамгын газар санхүүгээс асуухад бол 5 сарын дараа ажилтай боллоо гэхэд тэгээд тэтгэмж нь зогсдог. Сар сардаа тэтгэмжээ аваад явдаг. Тэгээд тэтгэмжийн олгох хугацаа нийт хугацаа нь бол 12 сар. 1 сарын дараа ажилд орлоо гэхэд энэ тэтгэмж олгогдохгүй зогсох, бага цалин авбал зөрүүг нь олгох ийм байдлаар явдаг юм байна шүү. Тэрнээс олон нийтэд ажилд орсон, ороогүйгээс хамаараад 12 сараар нь авдаг асуудал бол байхгүй юм байна гэдгийг нэгд хэлье.

2-т яах вэ ер нь бол иргэд юу хүсээд байна вэ гэж. Олон нийт. Төрийн аливаа энэ зөвхөн өргөдөл гомдлын гаргасан агуулга нь энэ 12 сарын тэтгэмжийн асуудал ярьж байгаа боловч цаанаа бол агуулга нь олон нийтийн зүгээс төрийн аливаа албан тушаалтнууд албан тушаал хашсаныхаа төлөө иргэдтэйгээ иргэдээсээ илүү давуу боломжийг эдлээд байна гэдэг асуудлыг л яриад байгаа болов уу л гэж би хувьдаа харж байгаа юм. Тэр Их Хурлын гишүүн байснаараа, Засгийн газрын гишүүн байснаараа өөр төрийн өндөр албан тушаалтнууд байснаараа яагаад заавал ингэж илүү боломж эдлэх ёстой юм. Одоо энд бид нар өнгөрсөн хугацаанд олон кэйсүүдийг засаад яваад байгаа юм.

Тухайлбал, Боловсролын зээлийн сан өнгөрсөн хугацаанд. Бид нар Авлигын тухай хууль, ялын бодлогыг чангалах хүрээнд төрийн өндөр албан тушаалтнуудын үр хүүхдүүдийг төрөөс олгох тэтгэмж урамшуулалд хамруулахыг болиулчихсан. Энэ бол албан тушаалаа ашиглаж байна гэдэг асуудал тухайн үед яригдаад болиулсан. Мөн төрийн өндөр албан тушаалтнуудын гэр бүлийг, төрийн өндөр албан тушаал эрхлэх асуудлыг хориглосон, хязгаарласан. Тендерт орох эрхийг нь хязгаарласан. Саяхан Ганбаатар гишүүний Үндсэн хуулийн цэцэд гаргаад байгаа асуудал. Их Хурлын гишүүн 4 жилийн хугацаанд байсан энэ хугацаандаа гэмт хэрэгт холбогдвол яахаараа Их Хурлын гишүүн байгаад гэмт хэрэгт холбогдохоороо шалгуулдаггүй юм гэдэг асуудал олон нийтийн зүгээс тавьж байгаа гэх мэтчилэн энэ асуудлууд бол хэн гэхээс үл хамаараад төрийн өндөр албан тушаал хашиж байгаа хүмүүс иргэдтэйгээ адилхан хуулийн бололцоо боломж ямар нэг давуу байдлыг эдлэх боломжгүй юм шүү. Үүнд олон нийтийн зүгээс бол илүү ач холбогдол өгч, энэ давуу боломж олгоод байгаа хуулиар өөрсдөдөө давуу боломжийг бий болгоод байгаа энэ

асуудлуудыг л та бүхэн цаашаа засаж сайжруул гэдэг ийм нийгмийн шаардлага гэж би хувьдаа ойлгож байгаа юм.

Тийм учраас үүнээс өөр цаашид ахиад өөр ямар төрийн өндөр албан тушаалтнуудад хуулиар олгогдсон давуу боломжууд байна вэ гэдгийг бас Их Хурал бас өөрөө эргэж харж, заавал иргэдээс гомдол гаргаж, 100 мянган гарын үсэг цуглуулж ингэж байдаг биш, иргэдийн мэдэх эрхийн хүрээнд хэн нэг давуу байдал бий болгочихсон зүйлүүдээ л та бүхэн болиоч гэж иргэд олон нийтийн зүгээс бол тавьж байгаа шаардлага гэж хувьдаа ойлгож байгаа. Тийм учраас бид нар бол цаашдаа зөвхөн энэ 12 сарын тэтгэмж гэхгүйгээр ер нь бол төрийн өндөр албан тушаалтнууд өөрсдөдөө хуулиар олгогдсон энэ бололцоо, боломж, давуу байдлуудыг арилгах, бүгдээрээ Үндсэн хуулийн зарчмаар ижил тэгш байх энэ зарчмыг л цаашдаа хаана, хаанаа анхаарч явах ёстой юм байна гэж би хувьдаа харж байна.

Тийм учраас цаашдаа энэ хуульд нийцүүлээд үнэхээр боломж олгочхоод байгаа энэ асуудлыг бол засаад явах, өнөөдрийн хэлэлцүүлгээс ажлын хэсэг гаргаад явах нь зүйтэй л гэж ингэж бодож байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн үг хэлье.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Бид бол ардчилсан нийгэмд амьдарч байна. Хууль, эрх, үүргийн хувьд болбол хүн бүр тэгш эрхтэй байх ёстой. Тиймээс өнөөдрийн энэ цахим өргөдлийн системд Цогбадрахын Батболдын Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41.9 дээр заасан Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацааг дуусгавар болгосны дараа 12 сарын хугацаатай тэнцэх тэтгэлэг авах, мөн цаашлаад бага цалинтай ажилд орсон бол дүйцүүлж тэтгэмж авах гэдэг энэ хуулийн заалтыг хүчингүй болгох саналыг 100 хувь дэмжиж байгаа юм. Ард иргэд өнөөдөр хөдөлмөрийнхөө үр шимээр амьдарч байхад төрд ажиллаж байгаа, Улсын Их Хуралд ажиллаж байгаа хүмүүс маань 12 сарын тэтгэмж авна гэдэг шударга биш байна. Энэ бол тэгш эрх нэрийн доор онцгой эрхийг бий болгож байгаа юм шиг харагдаж байгаа.

Тэгэхээр шударга ёсны шинэ нийгмийг бид нар бий болгох юм уу, эсвэл энэ давхар стандартыг тогтоох юм уу гэдгийг энэ удаа хариулах цаг ч юм шиг ингэж харагдаж байгаа юм шүү. Тэгэхээр хөдөлмөрлөсөн хүн бол хөдөлмөрийнхөө үр шимээр, татвар төлсөн иргэд бол татвар төлснийхөө хувь хэмжээгээр нийгмийн тусламж, үйлчилгээг хүртдэг. Төрд ажилласан хэн нэгэн төрийн тусгай хангамж эдлэлгүйгээр Хөдөлмөрийн хуулийнхаа дагуу асуудлыг шийдвэрлэдэг ийм байх хэрэгтэй байна. Тэгэхээр энэ бол шударга байдлын хамгийн энгийн хамгийн суурь зарчим гэж ингэж үзэж, дэмжиж байгаа энэ саналыг.

О.Номинчимэг: Дэмжиж үг хэллээ. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр бид нэг зүйлийг ойлгохгүй байх шиг байгаа юм. Ойлгоод попроод байдаг юм уу. Их Хурлын гишүүн хүн чинь мандат авсан хүн байхгүй юу. Олон түмний мандат авсан хүн. Төр барьж байгаа хүн байхгүй юу. Тийм учраас олон түмний мандат авсан учраас энэ хүнийг тодорхой хэмжээний хуулийн хамгаалалтууд байдаг. Нэг хүнээр төрийн шийдвэр гарах тохиолдол ч бий. Сонгуулийн үр дүнгээр. Жишээлбэл, Дашбалбар тийм байсан. 1 хүнийг ямар нэг байдлаар яаж ч болох тохиолдол Монголын түүхэнд гарч болзошгүй. Тийм учраас

энэ мандатын эзнийг бол бас хуулиар хамгаалсан юмнууд хийж өгдөг юм. Одоо та нарын өнөөдөр ярьж байгаагаар бол Ерөнхийлөгч, Ерөнхий сайд бүгд тэгш эрхтэй байх ёстой юм байна. Маргаашаас эхлээд эд нарын тэр машин тэргийг зогсоо. Тэр янз бүрийн хамгаалалттай явуулдгийг нь болиул. Ийм л зүйл хэлж байна шүү дээ. Яг л тэр Үндсэн хуулийнхаа дагуу бүгдээрээ тэгш эрхтэй байх ёстой юм бол бүгдээрээ тэр машин тэрэг, хамгаалалтаа аваад, тэгээд боль. Бүгдээрээ гудамждаа гараад алхацгаа. Энэ төрт улстай юм уу, үгүй юу энэ Монгол орон. Энэ төрийн нууц гэж байдаг юм уу, үгүй юм уу. Олон түмний мандат авсан хүн энэ чинь. Энийгээ бид нар буруугаар ашиглаад байгаа нөхдүүдийг л харин шийдэх тухай л асуудал.

Төр тогтвортой байх ёстой гэдэг үүднээс энэ бүх хамгаалалтууд байдаг. Яагаад гэвэл эд нар чинь шийдвэр гаргаж байгаа төрийн түшээ байхгүй юу. Төр авч яваа хүмүүс байхгүй юу. Өөрөө жишээлбэл сая бол судалгаа муу хийсэн байна л даа. Солонгост тийм юм байдаггүй. Японд бий. 1,2 сая иен авдаг. Британид, Англид бий. 8 сарын тэтгэмж авдаг. Германд бий. Германд бараг насан туршдаа. Төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан, нууцтай ажиллаж байсан хүмүүс. Европын дийлэнх орон ийм. Манай хуулийг хийхдээ Германы хуулийг харж хийсэн. Ерөнхийдөө манай хууль чинь бол Германы хууль дээр суурилж хийсэн Үндсэн хууль. Энэ заалтыг оруулахдаа тэгж л хэлсэн юм байна лээ. Би тухайн үед бас Үндсэн хууль хийж байсан юм гишүүдээс асууж байсан. Яагаад ийм юм орсон юм бэ гэж. Энэ бол нууцын хугацаатай холбогдолтой юм гэж ийм л зүйл юм билээ.

Нэр томьёоны хувьд бол өөрчлөх тухай асуудлууд байж магадгүй. Тэгэхдээ 30 хэдэн жил явж ирснээ гэнэт ухаардаг тэнэгийн ухаан хойно гэдэг шиг юм байж болохгүй шүү дээ. Нэг бол тэр Үндсэн хууль хийсэн хүмүүс тэнэг байсан байна. Нэг бол бид тэнэгэрсэн байна. 30 хэдэн жилийн дараа шүү дээ. Тэгэхээр бид нар аливаа шийдвэрийг гаргахдаа маш сайн боддог байх хэрэгтэй. Ер нь шийдвэр гаргахдаа өнгөрсөн, өнөөдөр, ирээдүй гэсэн ийм 3 цаг гаргах ёстой. Өнгөрснөө сайн мэдэж байгаа, өнөөдрийгөө сайн авч яваа хүн ирээдүйг тодорхойлж чаддаг. Тэрнээс биш популизмаар биш.

Энэ төр Монголын төр. Монголын төрөө бид нар яаж авч явах вэ гэдэг асуудлыг л бодож, энэ Үндсэн хууль энэ бүх юмнуудаа хийдэг. Тийм учраас бас энэ дээр ажлын хэсэг гараад ажиллахдаа тэр өмнө нь яагаад энэ орсныг хараарай. Германы хуулийн тогтолцоонд түшиглэж хийсэн юм билээ. Тэгээд энэ бүгдээ бид нар сайн бодох ёстой.

Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний мандатыг авсан хүн. Энэ үүргээ сайн гүйцэтгэх ёстой шүү харин. Энэ мандатыг авсан хүн ингээд жирийн иргэн гэдэг энэ 2-ыг харьцуулж ойлгож бас болохгүй юм байгаа юм. Ард түмний төлөө зүтгэх үүрэг хүлээсэн хүмүүс байхгүй юу. Тэгээд тэд нарыг хамгаалдаг.

О.Номинчимэг: Аюушийн Ариунзаяа гишүүн үг хэлье.

А.Ариунзаяа: 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараагаар бүрдсэн 126 гишүүнтэй парламентыг харлуулах ажиллагаа байж болохгүй гэдгийг бол дахин хичээнгүйлэн гуйя. 1 дүгээрт.

1990 оноос хойш явж байгаа энэ зохицуулалт нь 2006 онд өмнөх албан тушаал дээр нь, өмнөх эрхэлж байсан ажил дээр нь эргүүлэн ажиллуулах тийм боломжгүй бол ажил эрхлэх хүртэл 12 сарын хугацаанд тухай бүр нь тэтгэмж өгөх ийм заалт байсан. Түрүүн өргөдөл гаргасан иргэн бол 12 сар бүтнээр нь 1 удаадаа өмнө нь

бол 12 сар хүртэл хугацаа байсныг 12 сараар өгдөг болсон гэж өөрчилсөн гэж буруу ташаа мэдээлэл өглөө. Та эргээд хуулийн заалтуудыг хараарай. 1 нь болохоор ажил эрхлэх хүртэл хугацаанд гэж томъёолсон байсан бол 2024 оны 5 сард ажил эрхлээгүй бол гэж үг нь л өөрчлөгдсөн болохоос биш 12 сарын хугацаанд 1 удаадаа 12 сараар нь өгч байгаа асуудал огт биш шүү. Түрүүний Сандаг-Очир гишүүний хэлсэнчлэн маргааш нь шууд ажилд орсон ч бай шууд тэгвэл энэ тэтгэмж нь олгогдохгүй. Ажил хөдөлмөр эрхлэх хүртэл нь энэ бол тухай сар бүрд нь яригдаж байгаа асуудал байсан. Одоо ч гэсэн байна гэдгийг бол хэлмээр байна.

Гишүүд Хөдөлмөрийн тухай хуулийг ч гэсэн бас онцолж уншмаар байна. Ойлгомоор байна. Ажилгүйдлийн тэтгэмж авахаас үл хамаарч байгууллага тухайн ажилтандаа тэтгэмж өгдөг юм. Байгууллага гэдэгт төр, хувийн хэвшил, өмчийн хэлбэр үл хамаарч байгууллага Хөдөлмөрийн хуулиар ажилтныхаа өмнө хүлээж байгаа үүрэг бий. Тухайн байгууллагад 6 сараас 2 жил хүртэл ажилласан бол Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1.1-ээр хамгийн багадаа 1 сарын тэтгэмж өгөх үүрэгтэй. 1 ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх. 82.1.2-т 2 жилээс 5 жил хүртэл ажилласан бол 2 ба түүнээс дээш сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмжийг өгнө буюу хамгийн багадаа 2 сарын тэтгэмж өгнө шүү гэдэг үүргийг Хөдөлмөрийн хуулиар үүрэгжүүлсэн болно.

82.1.3.Тухайн байгууллагад 5-10 жил ажилласан бол хамгийн багадаа 3 сар ба түүнээс дээш. 10 ба түүнээс дээш л жил ажилласан бол хамгийн багадаа 4 сар, түүнээс дээш үндсэн сарын цалинтай тэнцэх тэтгэмжийг олгох үүргийг ажил олгогч хүл бүтээж байгаа. Энэ дотор бол хувийн хэвшил ч бай, төр мөн адил орж байгаа.

Төрийн албан хаагчдыг яг одоо цомхотгож байгаа энэ үедээ төр танд тэтгэмжээ өгч байгаа юу, үгүй юу гэдгийг төрийн албан хаагчид маань бас нэхэх энэ боломж нь Хөдөлмөрийн тухай хуулиар байгаа шүү. Маш олон төрийн албан хаагчид яг бас ажил хөдөлмөргүй болж байгаа нь бол харамсалтай. Энэ бол төрийн өөрийн алдаа байгаа. Тэгэхээр ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгож байгаа эсэхээс үл хамаарч ажил олгогч эдгээр хуулийн заалтаар тэтгэмж олгодог юм шүү. Энийг бол та бүхэн маань бас маш сайн ойлгож, энэ хөдөлмөрийн тухай хуулийг зөрчиж байгаа энэ явдал нь өөрөө цаад агуулгаараа Үндсэн хуулийг бас зөрчиж байгаа шүү гэдгийг бас энд нь сануулах нь зүйтэй байх гэж бодож байна.

Улсын Их Хурлын гишүүн бусдаас давуу эрх эдлэх ёсгүй. Би үүнтэй бол санал нэг. Гэхдээ нөгөө талдаа зоос 2 талтай байдагтай нэгэн адил давуу байдал эдлэхгүй ч дутуу байдлыг бас үүсгэмээргүй байна. Улсын Их Хурлын гишүүн болсноороо бусдаасаа дутуу эрхтэй баймааргүй байна. Үнэнийг хэлье. Энийг ч гэсэн бас ажлын хэсэг бас хараарай. Ер нь бол парламентын дархлааг бол маш ихээр сулруулж, Улсын Их Хурлын гишүүн бүр нэг л их баян олигарх, нэг л их муу хүн шиг харуулдгаа болимоор байна.

О.Номинчимэг: Үг хэллээ. Зулпхар гишүүн үг хэлье.

С.Зулпхар: Ямартай ч Цогбадрахын Батболд иргэдийн 100 мянган гарын үсгийг цуглуулаад, тодорхой асуудлаар санал гаргаад ингээд Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа нь өөрөө их тийм сайшаалтай. Энэ бол олон ургалч үзлийг бид бас нийгэмдээ хэвшүүлж болж байгаагийн бас нэг илэрхийлэл байх гэж ойлгож байгаа юм.

Гол нь би түрүүн бас асуулт асуухдаа хэлсэн. Иргэдийн оролцоо бол олон хэлбэрээр бол хангагдах ёстой бол энэ бас оролцооны бас нэг хэлбэр. Энэ чиглэлээр та санаачилга гаргаж байгаа нь бол өөрөө бас сайшаалтай байна. Цаашдаа ч гэсэн ийм санаачилгууд иргэдээс гарч цахим засаглалын бидэнд бий болгосон энэ дижитал технологиор бас их биеллээ олох байх гэсэн ийм ойлголттой байна.

2 дахь зүйл таны өргөдөл манай 100 мянган иргэдийн өргөдөл бол ийм л зүйл байгаа гэж би ойлгосон. Одоо өргөдлийг уншихаар зэрэг энэ бол өөрөө нийгмийн хамгааллын тодорхой тогтолцоо байгаа. Тэр тогтолцоогоор хангагдсан эрх бол хүн болгонд бол тухайн жишээ нь тогтолцоонд хамрагдсан хүн болгонд эрх тэгш байх юм л гэдэг энэ л асуудлыг та хөндсөн байна. Тэгэхээр энэ талаас нь аваад үзэх юм бол гарцаа байхгүй тийм. Сүүлд бид нар 2023 оны 7 сарын 7-нд Нийгмийн даатгалын багц хуулийг баталсан. Тухайн хуулийг батлахтай уялдуулаад нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийг баталсан. Тэр дотор бол ажилгүйдлийн тэтгэмжийг маш тодорхой заагаад өгчихсөн. Яаж олгох вэ гэж. Энд сууж байгаа хүмүүс бол ихэнх нь төрд юм уу, эсвэл даатгал төлсөн тодорхой салбараасаа шалтгаалаад 15-аас дээш жил ажилласан хүмүүс байгаа бол энэ төлсөн шимтгэлийнхээ хүрээнд энэ хүмүүс ажилгүйдлийн тэтгэмж авах бүрэн боломжтой гэж байгаа юм. Тухайлбал, жишээ нь сүүлийн 9 сарынхаа хөдөлмөрийн хөлстэй тэнцэх хэмжээгээр 70 хүртэлх хувиар бол ажилгүйдлийн тэтгэмж авна. Энэ бол зохицуулагдсан юм байна. Энийг бол иргэд хөндсөн юм байна гэж ойлгож байна. Энэ хүрээнд нь бол яг өргөдлийн хүрээнд энийг л хэлэлцээд явах байх гэсэн ийм бодолтой байна.

Нөгөөтээгүүр яах вэ, сая Ариунзаяа гишүүн ч гэсэн хэлж байна. Бас журамлагдсан ийм зүйлүүд бий. Энийг ажлын хэсэг бас нарийн үзэх ёстой. Хөдөлмөрийн харилцаа бол зарим зүйлийг нээж өгдөг. Тэр нээж өгсөн эрх нь бол ямар байх вэ гэдгийг саяын Даваасүрэн гишүүний бас хэлээд байгаа зарим асуудалтай уялдуулсан байдлаар нарийвчлан судлах хэрэгтэй байх. Бид бол аливаа зүйлийг тал талаас нь ингээд нарийн судалж байж ийм рационал шийдвэр гаргана шүү дээ. Рационал шийдвэр гаргахгүй бол болохгүй учраас энэ талаас нь судална. Иргэд маань өөрсдөө оролцоно. Манай Батболд өөрөө бас оролцоод явах байх. Гэхдээ үндсэн таны хэлж байгаа, гаргаж байгаа өргөдөл бол хүлээж авахаар байна гэж би ойлгож байгаа юм. Хүлээж авахаар байна. Энэ асуудал болбол саяын хуулиар зохицуулагдчихаж болно.

Нөгөөтээгүүр бас нэг зүйлийг бас энд хэлмээр байна. Бид бас хэтэрхий популизм хийдэг зүйл рүү бүгдээрээ л орж байна. Өчигдөр л гэхэд манай жишээ нь Ардчилсан намын дарга бол маш сонин мэдэгдэл хийлээ шүү дээ. Хөдөлмөрийн хөлсний дунджаар хэдүүлээ цалин авъя гэдэг юм ярьж байна. Хөдөлмөрийн хөлсийг 3 янзаар тогтоодог. Энэ хүн бол сайн мэдэж байх ёстой. Хөдөлмөрийн хөлсийг нэг бол бүтээмжээр тогтооно. 1 бол гүйцэтгэлээр тогтооно. 1 бол ажил, албан тушаалын тухайн хүний жишээ нь ямар ажил, албан тушаал байна. Түүгээр нь тогтоодог. Үүнээс өөрөөр бол хөдөлмөрийн хөлсийг социализмын үед ч гэсэн тэгшитгэж тогтоож байгаагүй. Тэгэхээр ийм зүйлээр хэдүүлээ иргэд рүүгээ яриад байх юм бол бид иргэдээ буруу зүйл рүү хөтөлж байна гэсэн үг. Бодлогын нам бол биш болж байна гэсэн үг шүү. Бид аль аль нь бодлогын нам байх ёстой. Тэгж байж энэ дээр аль болох бага популизм хийх ёстой. Судалгаа шинжилгээ дээр суурилсан байх ёстой. Тэгээд эцсийн бидний гаргаж байгаа шийрүүд бол рационал байх ёстой. Энэ талаас нь би зориуд хэлж байгаа юм. Ялангуяа тухайн хүн бол хувийн хэвшилд компанийн захирал байсан хүн компанийн захирал болон гүйцэтгэх ажилтан 2-ын

цалин бол газар тэнгэр шиг ялгаатай байгаа шүү дээ. Ийм байсаар байтал аваачаад ийм хариуцлагагүй зүйл яриад, нийгмийг араасаа бас дагуулж байгаа нь бол болохгүй гэдэг зүйлийг би өнөөдөр зориуд хэлж байна.

Цаашдаа ч гэсэн Их Хурлын гишүүд рационал шийдвэр гаргана шүү. Бид популизм хэтэрхий хийж болохгүй гэдгийг энд хэлье. Баярлалаа.

О.Номинчимэг: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн үг хэлье.

Г.Уянгахишиг: Батболд хуульч ямар ч байсан иргэдийг төлөөлж энэ өргөдлийг гаргахдаа бол тодорхой суурь үндэслэл, судалгаануудаа бол хангалттай түвшинд хийсэн байна гэж харж байна. Тэгээд энэ асуудлыг яах арга байхгүй Их Хурлын гишүүд гэдэг бол төсвөөс цалинжиж байгаа. Иргэдээс сонгогдож байгаа. Тэгэхээр ажил олгогчийн хувьд бол яалт ч байхгүй төсвөөс цалинждаг хүмүүс. Тэгэхээр төсвөөс цалинжиж байна гэдэг маань татвар төлөгчдийн төлөөлөл, сонгогч иргэдийн зүгээс цалинтай холбоотой, тэтгэмжтэй холбоотой тусгайлсан нөхцөлүүдийг авч хэлэлцэх асуудал тавих нь бол зарчмын асуудал гэж харж байна.

Харин энэ асуудлыг сая гишүүдээс гарч байгаа нэлээн олон саналууд байна. Асуултууд байна. Тодруулгууд байна. Энийг бол яалт ч байхгүй ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсэг дээр бол судалж үзэх ёстой асуудлууд байна. Жишээлэх юм бол тухайн үед буюу 1997 онд энэ хуулийн зохицуулалт орж ирэхэд тухайн үеийн нөхцөл байдал ямар байсан бэ. Одоогийн нөхцөл байдалтай харьцуулж үзэхэд ямар байна вэ гэдгийг бас бид нар харж үзэх ёстой. Жишээлэх юм бол магадгүй төрийн албанаас Их Хурлын гишүүн болох тэр шилжилт өндөр байсан байж магадгүй юм. Тэр тохиолдолд тухайн төрийн албан хаагчийн хувьд Их Хурлын гишүүнээс буусны дараа тухайн ажлаа эргээд томилогдох гэдэг юм уу, төрийн албанд буцаад томилогдох энэ асуудал дээр хугацаа шаарддаг байсан байж магадгүй. Тэгэхээр иймэрхүү асуудлууд гардаг үндэслэлүүд дээр энэ тэтгэмжийн асуудал яригдаж хуульд орж ирсэн байх магадлалтай. Тэгэхээр энэ нь өнөөдрийн нөхцөл байдалд бас яаж бууж ирэх ёстой вэ, яаж зохицуулах ёстой вэ гэдгийг бид нар бас харах ёстой байх.

Нөгөө талаасаа Даваасүрэн гишүүний яриад байгаатай бол би санал нийлэхгүй байгаа. Өөрөөр хэлэх юм бол нууц хадгалах үүрэг гэдэг бол гишүүнээр сонгогдоод, нууцтай харьцаж байгаа ажилтны хувьд угаасаа бид нарт тийм үүрэг байгаа. Хуулиараа ноогдчихсон үүрэг. Тэрнээс биш юу гэдэг юм тэтгэмж авч байгаа нь, ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа нь нууц хадгална. Авахгүй байгаа нь нууц хадгалахгүй гэдэг ийм асуудал байхгүй шүү дээ. Тэгэхээр бид нар дээр юу гэдэг юм тэтгэмж авах гэж байгаа тохиолдолд тухайлсан нарийвчилсан гэрээ хийдэг юм уу тийм асуудал байгаа юм шиг ойлгогдоод байна л даа. Өөрөөр хэлэх юм бол чи хэрвээ жил ажиллахгүй. Өөр ажил хийхгүй гэж байгаа бол нууц хадгална шүү гэдэг ийм гэрээ байгуулагдаад байгаа юм уу. Тэгэхээр ийм юм байхгүй шүү дээ. Тэгэхээр тэр тэтгэмжийг 12 сарын тэтгэмжийг авсан ч бай, аваагүй ч бай Их Хурлын гишүүн байсан бол, төрийн нууцтай харьцаж байсан бол төрийн нууцынхаа хуулийн дагуу Их Хурлын гишүүнийхээ эрх, үүргийн дагуу тэрний нууцлалыг хадгалах үүрэг нь байж л байгаа. Тэгэхээр энэнтэй бас хутгамааргүй байна.

Нөгөө талаасаа бид нар хувийн хэвшил дээр мэддэг. Өрсөлдөхгүй байх гэж байдаг буюу нууц хадгалах, өрсөлдөхгүй байх гэрээ байгуулсан тохиолдолд тэтгэмж биш харин цалингийн нөхөн олговор гэдэг юмыг өгдөг. Энэ бол гэрээгээр тохиролцоод шийддэг асуудал. Тэгэхээр Их Хурлын гишүүнтэй холбоотойгоор одоо

зарим албан тушаал эрхэлж байсан хүмүүсийн хувьд тусгай чиг үүрэгтэй байсан гишүүдийн хувьд хэрвээ ийм асуудал үүсэхээр бол энийг бид нар тусад нь зохицуулах ёстой. Энэ дээр тусдаа гэрээ байгуулах ёстой. Тусдаа хуулийн зохицуулалтууд байх ёстой. Тэгэхээр энийг бас бид нар эргэж харах ёстой юм байна гэдгийг өнөөдрийн яг энэ хэлэлцүүлгийн явцад бол харагдаж байна л даа.

Тэгэхээр цаашид ер нь бол аливаа зүйл өөрөө Зулпхар гишүүнтэй санал нэг байгаа. Рационал байх ёстой. Бид нар зарчимтай байх ёстой. Асуудлуудын үндэслэлүүд адилхан байх ёстой. 1 зарчим дээрээ байх ёстой. Тэгэхээр нэгэнт ажил олгогчийн зүгээс тэтгэмжийг нийгмийн даатгалынхаа системээр явна гэвэл түүгээрээ явахад асуудал байхгүй. Тэгэхээр энэ асуудлаа ажлын хэсэг дээрээ зохицуулаад явах байх. Харин тэр цалинтай холбоотой асуудал дээр бол улс төржилт гэж харж байгаа шүү. Яг цэвэр улс төржилт яваад байна.

О.Номинчимэг: Саруулсайханы Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 100 мянгаас доошгүй иргэн өргөн мэдүүлбэл тухайн асуудлыг Улсын Их Хурал дээр хэлэлцүүлэгдэнэ гэж заасан. Тэгээд гэсний дагуу өнөөдөр хуульч Батболд маань 8 хоногийн дотор 100 мянган хүний саналыг аваад энэ асуудал маань өнөөдөр Улсын Их Хурлын гишүүдийн 12 сарын тэтгэмжийг хасах тухай санал хэлэлцүүлэгдэж байгаа юм. Тэгээд энэ 100 мянган хүнийг харахаар 60 мянган хүн нь болохоороо 40-өөс доош насны залуучууд бол энд саналаа өгсөн байгаа. Тэгээд бид бүхний харах ёстой зүйл бол Монгол Улс бол залуучуудын орон. Тэр утгаараа маш олон залуучууд би ямар ч дуу хоолой байхгүй миний яриаг хэнд ч угаасаа сонсохгүй юм чинь гээд итгэл алдсан шинжтэй байдаг.

Гэхдээ өнөөдөр Батболд хуульч энд суугаад, энэ Улсын Их Хурлын гишүүдийн 12 сарын тэтгэмжийг хасах тухай яриад сууж байна гэдэг чинь өөрөө манай улсын бүх иргэдэд тэр боломж нь байж байгаа. Залуучууд бид нар өөрсдөө идэвхтэй байх юм бол өөрчлөлтийг хийж болно гэдгийг харуулж байгаа маш том үйл явдал болж байна гэж харж байгаа.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүний 12 сарын тэтгэмжтэй холбоотойгоор бол Улсын Их Хурлын гишүүний энэ тэтгэмжээс болж Улсын Их Хурлын гишүүн болно гэдэг хүн бол байхгүй байх. Энэ тэтгэмж байхгүй боллоо гээд би бас Улсын Их Хурлын гишүүн болохоо больё гэдэг ч хүн байхгүй. Тэгээд яагаад тэрийг хэлж байна гэхээр манай энэ Улсын Их Хурлын гишүүдэд маань сонгуультай холбоотой асар их зардлыг бид нар хуулиараа хуульчлаад гаргаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр ухуулагчийн зардлыг бас зайлшгүй ярих шаардлагатай байна л даа. 200-400 хүн тутам, сонгогч тутамд 1 ухуулагчийг бид нар цалинжуулж гаргана гээд Сонгуулийн тухай хууль дээр гаргаад өгчихсөн. Энэ нь болохоороо иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор гэдэг. Өнөөдөр бид нар цахимаар хүртэл саналуудаа өгөөд байж болж байхад заавал тэнд нэг хүнд цалинжуулж, бид нар сонгуулийн ухуулагчаар ажиллуулна гэдэг бол шууд санал худалдан авалт байгаа. Тэгэхээр энгийн иргэдийгээ бид нар улс төрөөс мөнгөнөөс хамааралтай улс төрөөс гарах, мөнгөгүйгээр улс төр хийх боломжийг нь нээхийн тулд энэ сонгуулийн ухуулагч гэдэг зүйлийг бид нар байхгүй болгох шаардлагатай.

Тэгэхээр дараагийн ээлжид ч гэсэн бид нар бас залуучуудаараа дэмжиж маш хүчтэйгээр өөрчлөх ёстой зүйлээ Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулаад,

мөнгөгүй хүмүүс мөнгөгүйгээр энгийн залуучууд маань бас энэ сонгуульд өрсөлдөх боломжийг нээж өгөх шаардлагатай гэдгийг бас энэ дашрамд хэлэхийг хүслээ.

О.Номинчимэг: Үг хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Яг энэ асуудлаар иргэн Батболд өөрөө Үндсэн хуулийн цэцэд хандаад, тэгээд бага суудлын хуралдаанаар Үндсэн хуулийн маргаан бол үүсгэхээс татгалзсан юм байна энэ асуудлаар. Тэгээд бага суудлын хуралдаан болоод Үндсэн хуулийн цэцийн маргаан үүсгэхээс татгалзсан гол үндэслэл нь юу вэ гэвэл энэ бол цэвэр Улсын Их Хурлын өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудал байна. Үүнд ямарваа нэгэн байдлаар Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаан бол үүсгэх үндэслэл бол харагдахгүй байна гэдэг ийм Бага суудлын хуралдааны шийдвэр гарсан юм байна. Тэгэхээр бид нар энийг бол харах ёстой байх гэж бодож байна.

2 дугаарт миний санал бол ажлын хэсэг байгуулж байгаа юм байна. Тэгээд ажлын хэсэгт би өөрөө орох саналтай байна. Тэгээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг бас бид нар жаахан бодож байгуулах ёстой юм болов уу. Дандаа нөгөө шинээр сонгогдсон гишүүд дан ажлын хэсэгт орсон байна. Тэгэхээр жоохон холимог байдлаар хуучин туршлагатай парламентчдыг бас энэ бүрэлдэхүүнд оруулах ёстой болов уу. Энэ төрийг төлөөлж байгаа гээд маш хариуцлагатай ажил үүргийн цаана байгаа олон нюансууд байгаа. Тэгэхээр энэ зүйлүүдийг ч гэсэн судлахаас өгсүүлээд нэлээн судалгаа шинжилгээтэй үзэх ёстой болов уу гэж бодож байна. Тэгээд ганцхан тэтгэмжийн асуудал гэхгүй энэ асуудлыг дагалдуулаад гарах бусад асуудлуудыг ч гэсэн өргөн хүрээнд судлаад, тэгээд яг нөгөө гишүүдийн хөндөөд байгаа энэ тэнцвэрийн асуудал гэж байгаа. Тэгэхээр энэ тэнцвэрийг яг оновчтой, зөв тодорхойлох ёстой болов уу гэж бодож байна. Тийм учраас ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг манай 2 Байнгын хорооны дарга нар бас хараад харгалзаж үзээсэй гэж хүсэж байна. Тэгээд би өөрөө ажлын хэсэгт орох саналтай байна.

О.Номинчимэг: Санал хэллээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг хэлье.

М.Бадамсүрэн: Монгол Улсын иргэн Цогбадрахын Батболдоос санаачилж, 100 мянган иргэн гарын үсэг зурсан энэ хуулийн заалтыг хүчингүй болгох тухай саналыг бол би бүрэн дэмжиж байгаа.

2 дугаарт бараг Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө холбогдох Байнгын хороо өөрөө санаачилсан бол олон түмэнд их цэвэрхэн, нэр хүндтэй байж дээ гэж бодогдож байна. Энд ажлын хэсэг байгуулах шаардлагагүй гэж би бол үзэж байгаа Байнгын хороон дарга аа би саналаа хэлж байгаа юм. Энд бол ажлын хэсэг байгуулах шаардлагагүй гэж үзэж байгаа. Энэ тодорхой асуудал дээр юуг нь судалж, ажлын хэсэг байгуулах юм. Тэгээд энд шийдвэрлэхгүй бол Үндсэн хуулийн цэцэд аягүй бол дахин хандаж магадгүй. Хэрвээ тийм шийдвэр гарвал өмнө нь тэтгэмж авсан хүмүүс яах вэ гэдэг асуудал бас үүснэ. Энэ цэргийнхний тухайд бол 36 сарын тэтгэмж бол авдаг. Цэргийнхэн бол өөр байхгүй юу. Яагаад гэвэл 24 цагаар хэзээ ч бэлэн байдалд байдаг ийм онцгой горимд ажилладаг хүмүүс учраас үүнтэй бол хэн ч маргахгүй. Цэргийнхний тухайд.

Улсын Их Хурлын гишүүд бол өөр. Тийм учраас энэ нийгмийн даатгалаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан тэр 24 сараас дээш хугацаанд ажилласан бол 50-70 хувиар сүүлийн 9 сарын дунджаар төлсөн тэтгэмжтэйгээ уялдуулаад, энийгээ ажилд орох хүртэл хугацаандаа авдаг энэ зохицуулалттайгаа

адилхан явчихад энэ болохгүй юм юу байгаад байгаа юм. Улсын Их Хурлын гишүүд гээд арай өөрөөр, иргэдэд болохоор 75 ажлын өдөр гэж байгаа юм. 3 сар гаруй. Тэгээд Улсын Их Хурлын гишүүнд болохоор 12 сар гээд ингээд илт өөр заачихаар чинь ингээд ямар ч хүн энэ дээр бол шударга бус байна гэж үзнэ л дээ. Тийм учраас энэ зүйлийг цэргийнхэнтэй бид нар адилтгаж үзэх ийм боломж байхгүй. Угаасаа нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа хүн бүр ажилгүйдлийн тэтгэмж гэж төлдөг шүү дээ. Дараа нь хэрвээ ажилгүйдэлд өртөх юм бол авна гээд. Тэгээд энтэй тэгээд юуг нь тэгээд л заавал байлгах гээд үзээд байдаг юм бол. Өмнө нь 30 жил тийм байсан гээд. Тэгээд өмнө нь 30 жил бүх юм нь тэгээд болоод байсан юм бол одоо бүх юм нь болохгүй яагаад байгаа юм.

Тийм учраас энэ өмнө байсан тэр үеийнх нь нөхцөл байдал өөр байсан гэж Уянгахишиг гишүүн хэлсэн. Тэрэнтэй би санал нэг байгаа. Зах зээлийн эдийн засагт дөнгөж шилжиж байх үед нөхцөл байдал өөр байсан. Одоо бол нөхцөл байдал өөр. Харьцангуй өргөн боломж гарсан. Хүмүүст ажил хөдөлмөр хийх тэр шилжилтийн үеийг бодвол. Тэгээд энэ чинь бол илт ойлгомжтой асуудал байгаа юм чинь энэ дээр заавал ажлын хэсэг гаргаад, энийг зөв, буруу гээд байхгүй. Тэгээд одоо шууд л энийг хүчингүй болгоё гээд л саналаа өгчихвөл нийгэмд их сайхан даа.

Тэгэхгүй болохоор ажлын хэсэг гараад, тэгээд юуг нь судлах гээд байгаа юм бол. Би тэрийг гайхаад байгаа байхгүй юу. Яг яана гээд байгаа юм. Бусад оронд ийм байдаг юм байна. Тийм учраас бид нар адилхан байя. Больё гэх гэх гээд байгаа юм уу. Бусад оронд чинь хөгжлийн түвшин өөр. Бид нар бас өөр байна. Хөгжихгүй байгаа шалтгааныг ард иргэд төр буруу удирдсанаас боллоо. Төрийн өндөр албан тушаалтнууд ашиг сонирхол, авлигын асуудалд оролцсоноос боллоо гэж дүгнээд байгааг ер нь бид нар бүгдээрээ ойлгож байгаа биз дээ.

Тийм учраас энийг удаан хэлэлцээд, ажлын хэсэг байгуулаад л ингэх тусам л парламентын нэр хүнд улам унана шүү. Тийм учраас шууд орж ирсэн дээр нь би бол горимын санал гаргая гэж бодож байгаа. Ажлын хэсэг байгуулахгүйгээр шууд хэлэлцээд, энэ заалтыг хүчингүй болгохыг дэмжээд явъя гэдэг би бол ийм саналтай байгаа. Тэгэхгүй бол энийг ингээд зөв, буруу гээд олон талаас нь ярих нь эрхийн асуудал даа гишүүний. Гэхдээ шууд ингээд энийг нь дэмжээд явчихъя гэдэг саналтай байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Бадамсүрэн гишүүн санал хэллээ. Ер нь зарчмын хувьд би ч гэсэн гишүүний хувьд бол энийг бас хүчингүй болгох дээр бол санал нэг байгаа юм. Одоогийн нөхцөл байдлаа хараад, манай улс төрийн нөхцөл байдал ямар байна. Ер нь бид энэ 30 жилийн хугацаанд улс маань өөрөө баялгийн хараалд идэгдээд энэ маань өөрөө ингээд систем рүү орчихсон ч юм харагдаж байгаа юм. Тэр бол тэгээд тусдаа мэдээж д яригдаад явах асуудал.

Гэхдээ яг өнөөдрийн хувьд бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиараа энэ нийтийн өргөдлийг орж ирэхээр ямар ч байсан холбогдох Байнгын хороо заавал хэлэлцэх юм байна лээ. Ингээд хууль хүчингүй болгоё гэвэл дахиад өөр процессоор бас явна. Тэгэхээр өнөөдөр бол энд санал хураалтаар хууль хүчингүй болгох боломж байхгүй. Дэгийн хуулиараа. Энд бас та түрүүнээс хойш олон гишүүд бас санал бодлоо илэрхийллээ. Хөдөлмөрийн хуулиар явах ёстой юм уу. Бид нар яг хөдөлмөрийн харилцаанд байгаа юм уу. Эсвэл Төрийн албаны тухай хуулиар явах ёстой юм уу. Бид нар яг төрийн албан хаагчийн юун дээрээ орж байгаа юм уу гээд энэ бүхний нюансыг гаргаад, ямар юмнууд байна гэдгийг нь нарийвчлаад л харчихъя гэсэн юм. Тэгэхээр ажлын хэсэг бол энийгээ хараад, энийг бас нэг зөв,

ул үндэстэй, суурьтай санал, дүгнэлт оруулж ирээд, тэгээд энийг угаасаа чуулганаараа хэлэлцээд явчих байх. Ер нь сая та хэллээ л дээ. Цэцэд хандана гээд. Тэгээд Баасанжаргал гишүүн хэлж байна. Энэ цэцэд хандаад цэц бол хүлээж авахгүй. Энэ бол Улсын Их Хурлын өөрийнх нь бүрэн эрхийн асуудал. Цэцийн маргаан биш байна гээд Үндсэн хуулийн зөрчил биш гэдгийг нь бол шийдчихсэн юм байна. Гэхдээ энд бол өнөөдрийн энэ 126-тай парламент бол иргэдийнхээ санал бодлыг бодлогодоо тусгая. Энэ саналыг нь хүлээж аваад хэлэлцье гэдэг энэ байр сууриас хандаад ихэнх олонх гишүүд маань бас дэмжээд явж байгаа гэдгийг хэлмээр байна.

Тэгш бусын асуудал ярих юм бол мэдээж энэ дээр өөр зөндөө олон асуудал байгаа. Бид нар сая цалин тэтгэвэр нэмэх гээд нийгмийн даатгалын тогтолцоо маань яаж байна гээд харах юм бол та бол цэргийг хэлж байна. Цэргийг бүгдээрээ ойлгож байгаа. Тэгтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээний албаныхан нэг ч төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй. Улсаас тэтгэмж авдаг. Энэ тэгвэл яагаад юм гэдэг асуудлууд ч гэсэн цаашаа хөрвөж гарах ёстой байгаад байгаа юм. Тэгээд энийг бол бид нар цогцоор нь бас харах ёстой. Өнөөдрийн асуудал дээр бол намын төлөөллүүд орсон энэ ажлын хэсэг нь байгуулагдаад, мэдээж энэ бол нэг их удаан бас судлаад байх асуудал бол биш байх гэж бодож байна. Тэгээд санал, дүгнэлтээ гаргаад дэгийнхээ дагуу явчих байх гэж бодож байна. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Баярлалаа. Юуны өмнө ер нь бол албан тушаал, эрх мэдлийг ашиглан илт давуу эрхтэй байдаг энэ шударга бус явдалд бол үнэхээр би ч гэсэн энд бол дургүй. Үүний эсрэг байдаг учраас өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төлөөлж парламентад гишүүн гээд ингээд сууж байгаа юм. Энэ талаар ярих гэж бас энд орж ирсэн. Тэгэхдээ миний хувьд жишээлэх юм бол би хөгжлийн бэрхшээлтэй учраас надад ийм онцгой зүйл өгөөч ээ, надад одоо юу гэдэг юм 1 хаалгаа, 1 сандлаа ингээд засаад өгөөч гэж 1 ч удаа хувьдаа шаардлага хүсээгүй. Миний ард байгаа адилхан хүмүүс дээр адил тэгш байдлыг бий болгооч ээ гэж парламент орж ирсэн байгаа.

Тэгэхээр бусад гишүүдтэй адилхан тэр хэмжээнд нь хүрэхийн тулд өнөөдөр ингээд л уралдаад л унах үедээ унаад, босох үедээ босоод л ингээд явж байгаа. Тэгэхээр Их Хурлын гишүүд дотор бол өнөөдөр тэр 30 жилийн өмнө байсан зүйлийг өнөөдөр нээгээд ярьж байна гэдгийг би юу гэж харж байна гэхээр манай энэ парламентын хувьд харьцангуй юм бол бага багаар ил тод болж байна. Иргэд өшөө олон гарын үсэг цуглуулаасай. Өшөө олон дабл стандарт байгаа зүйл дээр яриасай гэж би бодож байна. Нөгөө талд бид нар эмч, багш нарын нийгмийн хамгаалал хангалтгүй учраас жагсаж байгаа гэдгийг үг дуугүй улсаараа хараад сууж байгаа. Зарим ээж аав нар хүүхдээ өөрсдөө харьяагүй байж байгаа.

Нийгмийн хамгаалал халамжийг нь дэмжээгүй төрийн албан хаагчдаас бид нар ямар хариуцлага, үүргийг хүлээх вэ дээ. Өөрсдөө хүүхдээ өсгө. Өөрсдөө хүүхдээ хар. Энэ зарчим бас хаа сайгүй адилхан байх ёстой гэж би бодож байна. Тэгэхээр энийгээ бид нар төрийн албан хаагчдынхаа бүх төрөл дээр адилхан тавих ёстой. Улс төрийн албан хаагч байна уу, төрийн үйлчилгээ байна уу, төрийн алба ч байна уу. Хамаагүй. Энэ утгаараа бид нар энэ асуудал дээр гол нь нөгөө чиний лааг үлээчихвэл миний лаа тодрохгүй гэдэг шиг, Улсын Их Хурлын гишүүдийн аваад байгаа зүйлийг бүгдийг нь байхгүй болгоё. Парламент ингээ гэдэг нь зорилго юм уу. Эсвэл парламент орж байгаа хүмүүсийг илүү ил тод болгоод өгөөч, шударга болгоод өгөөч гэдэг хариуцлагын тухай иргэд хүсээд байна уу гэдгээ бид нар энэ

ажлын хэсэг дээрээ өшөө сайн ярьж, миний түрүүн хэлсэн тэр бусад оронд байгаа шилжилтийн хөтөлбөр байна уу, тэтгэмж гэж нэрлэх юм уу, хугацааг нь багасгах ёстой юу, эсвэл ажилгүйдлийн тэтгэмж авч чадахгүй байгаа жишээ нь миний дурдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртэхгүй байгаа зүйлийг адил хэмжээнд авчрах юм уу гэдэг энэ зарчмын асуудлаа бид нар ярих ёстой гэж бодож байна. Үүгээр далимдуулаад бид нар өшөө Улсын Их Хурлын гишүүдийн үүрэг, хариуцлагыг илүү сайн ярих ёстой гэж бодож байна. Ямар гишүүд яаж хүмүүстэйгээ ил тод харьцаж байгаа юм. Аль нь мэдээллээ өгдөг. Аль нь мэдээллээ өгөхгүй байгаа юм гэдэг дээр бид нар илүү ярьж, хариуцлагаа тооцох ёстой гэж би бодож байна.

Тийм утгаараа байвал энэ ажлын хэсэг илүү үр бүтээлтэй болно. Тэрнээс биш илүү нөгөө попортдог, хүмүүсийн уур гаргах мешок шиг, бай шиг болгоод гишүүд л байвал юу билээ. Нүдэнд орсон хог, шүдэнд орсон чигчлүүр шиг Их Хурлын гишүүн л бол энэ илүү эрхтэй гэж хардаг энийгээ бид нар бас хаана хаанаа ялгаж харах хэрэгтэй. Харьцуулж байгаа бусад орныхоо гишүүдийн нийгмийн хамгаалал, гишүүдийн нийгмийн баталгааг харьцуулаад судлах хэрэгтэй. Ямар нийгмийн хамгаалал, ямар нийгмийн баталгаатай болгоод иргэд мандатаа өгөөд тийш нь явуулж байгааг хараад бид нар өнөөдөр гишүүд бас юу туулж байгааг бас ярих хэрэгтэй. Улс орныхоо төлөө тангараг өргөнө гэдэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажилгүйдлийн тэтгэвэр авдаггүй шиг бүх юмны боломжоос доогуур хог, нохой шиг үзчихээд, эргээд та нар хариуцлага гэдэг юмыг шаардах нь өөрөө хүний ёсонд хэр нийцэх вэ гэдгийг бид нар харах ёстой, ярих ёстой гэж бодож байна. Тэгээд иймэрхүү зүйлүүдэд хамгийн их хохирдог бүлэг бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс. Дуугарч чаддаггүй хүмүүс байгаа.

Одоо өнөөдөр хэрвээ миний оронд ярьж чаддаггүй хүн байсан бол энэ дээр дуу хоолойгоо илэрхийлэхэд хэцүү л юм байна. Надад жишээлбэл тусдаа унаа ч байхгүй, миний хийж байгаа видеонд дохионы орчуулга ч байхгүй. Тэгэхээр энийг бид нар сайн судалж ярих ёстой шүү гэдгийг бас хэлье. Би ажлын хэсэгт орох саналтай байна.

О.Номинчимэг: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын иргэн Ц.Батболдоос гаргасан нийтийн өргөдлийг хэлэлцээд, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлд заасны дагуу уг асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулан танилцуулах үүрэг бүхий Төрийн байгуулалтын байнгын хороо болон Өргөдлийн байнгын хорооны гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулах нь зүйтэй гэж үзэж байгаа тул ажлын хэсэг байгуулах санал хураалт явуулъя.

Та бүхэнд “Ажлын хэсэг байгуулах” Байнгын хорооны тогтоолын төслийг тараасан байгаа.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.10 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо болон Өргөдлийн байнгын хорооноос тогтоох нь.

1.Нийтийн өргөдлийн цахим системд иргэн Цогбадрахын Батболдоос ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг буюу “хэрэв гишүүн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ажил эрхлээгүй бол 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгоно.” гэсэн заалтыг хүчингүй болгуулах асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Хэрлэн гишүүн, ажлын хэсгийн гишүүдээр Алтангэрэл гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Пунсалмаа гишүүн, Баасанжаргал гишүүн, Уянгахишиг гишүүн, Л.Энх-Амгалан гишүүн. Рэгдэл гишүүн сая нэрээ татаж, Баасанжаргал гишүүн, Саранчулуун гишүүн бас орох уу. Б.Бат-Эрдэнэ буюу Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Зулпхар гишүүнийг нэмээд, нийт 9 гишүүнтэй ажлын хэсгийн хамтарсан тогтоолыг уншиж танилцууллаа.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Бадамсүрэн гишүүний түрүүн гарсан горимын санал чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.1.3-ын горимын санал гэдэг нь Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал журмын талаар гаргасан саналыг хэлнэ гэж байгаа учраас Байнгын хороодын ажлын албаны ахлах зөвлөхүүдээс горимын саналыг энэ асуудлаар бол хураалгах боломжгүй юм байна гэсэн тайлбарыг хэлээд байгаа юм.

Хууль санаачлахад Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлах эрхтэй. Тэгэхээр энэ чинь хууль санаачлах гээд байна шүү дээ. Хүчингүй болгох гэдэг. Тэгэхээр энэ маань өөрөө гишүүдээс гарах гээд байгаа байхгүй юу. Эхлээд ажлын хэсэг гараад, энэ чинь хууль маань өөрөө хэлэлцүүлэгтэй, Байнгын хороо, чуулганаар асуулт хариулттай явна. Тэгээд эзэн биетэй ажлын хэсэгтэй. Хууль санаачлах, хүчингүй болгох энэ процесс бас явахаар байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлдсэн үү.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны хамтарсан тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Нийт хуралдаанд оролцсон гишүүдийн 63,4 хувиар Байнгын хорооны төсөл дэмжигдлээ.

Төрийн байгуулалтын болон Өргөдлийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

12.58 цаг.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ